

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

БЦГ	Байгалийн Цогцолборт Газар
БОАЖЯ	Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам
БОНХАЖЯ	Байгаль Орчин Ногоон Хөгжил Аялал Жуулчлалын Яам
БНБД	Барилгын Норм Ба Дүрэм
БОМТ	Байгаль Орчны Менежмент Төлөвлөгөө
БОННУ	Байгаль Орчны Нөлөөллийн Нарийвчилсан Үнэлгээ
БОНМС	Байгаль Орчин, Нийгмийн Менежментийн Систем
БО	Байгаль Орчин
БОНЭЗ	Байгаль Орчин, Нийгэм Эдийн Засаг
Д.Т.Д	Далайн Түвшнээс Дээш
ЕБС	Ерөнхий Боловсролын Сургууль
ЗГ	Засгийн Газар
МУ	Монгол Улс
МУУН	Монгол Улсын Улаан Ном
НЭЗ	Нийгэм Эдийн Засаг
ОНТХГН	Орон Нутгийн Тусгай Хамгаалалттай Газар Нутаг
СӨБ	Сургуулийн Өмнөх Боловсрол
ТХГН	Тусгай Хамгаалалттай Газар Нутаг
УТХГН	Улсын Тусгай Хамгаалалттай Газар Нутаг
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

ТЭМДЭГЛЭГЭЭ

Га	Гектар
Гц	Герц
дБ	Децибел
Км	Километр
м	Метр
м²	Метр квадрат
м³	Метр куб
Па	Паскаль
Тн	Тонн

АГУУЛГА

БҮЛЭГ.1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ	4
1.1. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ	4
1.2. КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	6
1.2.1. Уурхайн зохион байгуулалт	6
1.3. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ	7
1.3.1. Ордыг нөөц:	7
1.3.2. Далд уурхайн хэсэг:	9
1.3.3. Уулын малталтуудын хөндлөн огтлолтын талбай, уулын хэмжээ:	10
1.4. БАЯЖУУЛАХ ТЕХНОЛОГИ	12
1.4.1. Хүдэр ангилах хэсгийн ажиллах горим, хүчин чадал	13
1.4.2. Бүтээгдэхүүн гаргалт	14
1.4.3. Тоног төхөөрөмж сонголтын тооцоо	15
1.4.4. Талбай тоос дарах технологи	15
1.5. ТӨСЛИЙН ДЭД БҮТЭЦ	15
1.5.1. Талбай тоос дарах технологи	16
1.5.2. Уурхайн усан хангамж	16
БҮЛЭГ.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ	22
БҮЛЭГ.3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	24
3.1. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	24
3.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ	24
БҮЛЭГ.4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАНИЛЦУУЛГА	31
4.1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	32
4.1.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	33
4.1.2. Ногоон байгууламж, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	37
4.1.3. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	37
4.1.4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	37
4.1.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	38
4.1.6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	39
4.1.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	40
4.1.8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	44
4.1.9. Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	46
4.1.10. БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	48

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	4
Хүснэгт 2. Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлын цэгүүд	5
Хүснэгт 3. Ажиллах хүчний дэлгэрэнгүй мэдээлэл	6
Хүснэгт 4. Нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт	8
Хүснэгт 5. Уушиг уулын далд уурхайн уулын ажлын хэмжээ	11
Хүснэгт 6. Далд уурхайгаас ангилан ялгах цех-д нийлүүлэх хүдрийн хэмжээ болон агуулга	13
Хүснэгт 7. Баяжуулах хэсгийн ажиллах горимын тооцоо	14
Хүснэгт 8. Бүтээгдэхүүн гаргалтын тооцоо /Жил бүрээр/	14
Хүснэгт 9. Өрөмдмөл худгийн үзүүлэлт	16
Хүснэгт 10. Уурхай болон хотхоны ажилчдын унд, ахуйн усны хэрэглээ	17
Хүснэгт 11. Баяжуулах хэсгийн ажилчдын унд, ахуйн усны хэрэглээ	17
Хүснэгт 12. Баяжуулах хэсгийн тоос дарах усны хэрэглээ	17
Хүснэгт 13. Төслийн нийт усны хэрэглээ	17
Хүснэгт 14. РВЛ-80 маркийн гэрэлтүүлэгчийн техникийн үзүүлэлт	18

Хүснэгт 15. Нөлөөллийг тооцох аргачлал.....	24
Хүснэгт 16. Байгаль орчинд нөлөөлөх байдлыг тодорхойлох шалгуур.....	25
Хүснэгт 17. Агаарын чанарт нөлөөлөх байдлын үнэлгээний матриц	26
Хүснэгт 18. Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээний матриц	28
Хүснэгт 19. Амьтны аймагт нөлөөлөх байдлын үнэлгээний матриц	30
Хүснэгт 20. Байгаль орчны төлөвлөгөөний зардал задаргаа	32
Хүснэгт 21. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний нийт зардал	32
Хүснэгт 22. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал	33
Хүснэгт 23. Ногоон байгууламж нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний нийт зардал.....	37
Хүснэгт 24. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний нийт зардал.....	39
Хүснэгт 25. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний нийт зардал	40
Хүснэгт 26. Удирдлага, зохион байгуулалтын талаар авах арга хэмжээний зардал.....	45
Хүснэгт 27. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн нийт зардал	47
Хүснэгт 28. БОМТ-г оролцогч талуудад тайлагнах хуваарь	48

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1 Төслийн талбайн байршил	5
Зураг 1.2 Эдэлбэр газрын төрх байдал	5
Зураг 1.3 Жоншны илэрцтэй талбайг хашаалсан байдал.....	5
Зураг 1.4 Уурхайн бүтэц зохион байгуулалт	6
Зураг 1.5. Нөөцийн тооцоо	9
Зураг 1.6. Уурхайн одоогийн байдал	9
Зураг 1.7. /2022, 2023 онд олборлолтод өртсөн I-р хүдрийн биетийн дагуу зүсэлт/	10
Зураг 1.8. Гар аргаар ялган ангилах цехийн технологийн схем.....	13
Зураг 1.9. Манантуулагч буу.....	15
Зураг 1.10. Ус хангамжийн цэгүүдийн байршил.....	16
Зураг 1.11. Хоолны газар	19
Зураг 1.12. Ажилчдын амрах байр	19
Зураг 1.13. Уурхайн инженер техникийн ажилчдын ажлын өрөө.....	20
Зураг 1.13. Засварын газрын сэндвичийн барилга	21

БҮЛЭГ.1.ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ

1.1. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр: Дундговь аймгийн Сайнцагаан, Өлзийт сумдын нутаг дэвсгэрт байрлах “УУШИГ УУЛ-1 хайлуур жоншны ордыг ил, далд аргаар ашиглах” төсөл

Төслийн зорилго: Төсөл хэрэгжүүлэгч компани нь эх орондоо ашигт малтмалын хайгуул, эрэл-хайгуулын ажил эрхлэхийн зэрэгцээ ашигт малтмалын нөөцийг илрүүлэх, ашиглах үйл ажиллагааг явуулах гол зорилготой. Үүнийхээ зэрэгцээ байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалах ажлыг Монгол улсын хуулийн дагуу мөрдлөг болгон хийж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх стандартыг баримтлан ажиллахыг эрхэмлэдэг. Үүнд:

- Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжуудыг дагаж стандартуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох;
- Байгаль орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх, компанийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учрах нөлөөллүүдийг нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсийг харгалзан сөрөг нөлөөг бүрэн хяналтад байлгах;
- Байгаль орчны ажилд үйлдвэрлэлийн хамгийн шилдэг практикийг байнга хэрэгжүүлэх, байгаль орчны үзүүлэлтүүдийг сайжруулахад өөрсдийн үйл ажиллагааг хянах ба үнэлэх;

Дээрх үүргийг хэрэгжүүлэхийн тулд:

- Байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, тайлан, хэрэгжилтийг компанийн удирдлага, эрх бүхий байгууллагуудад танилцуулах.
- Бүх ажиллагсад, гэрээ гүйцэтгэгч нарт байгаль орчны талаар баримтлах бодлогыг ойлгуулснаар тус компанид гүйцэтгэж буй үүрэгтээ зохицуулан байгаль орчны үүрэг хариуцлагаа ухамсарлаж, мөрдөх нөхцөлийг хангах;
- Үйлдвэрлэлийн ойр оршин сууж буй ард иргэдэд компанийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар үнэн зөв мэдээллийг хүргэж, санал шүүмжлэлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх замаар ажил хэрэгч харилцааг хөгжүүлэх;

Энэхүү бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л нөөцөөр хангах зэрэг зорилт тавин ажиллаж байна.


Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Аж ахуйн нэгжийн нэр	“ИДЭР МАКС” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011811242
Регистрийн дугаар	6471919
Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар	Ашиглалтын MV-021876, 117.26 га Хайгуул XV-021400, 3718.95 га
Үйл ажиллагааны чиглэл	Уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх
Хаяг	УБ хот, Хан-уул дүүрэг, 15-р хороо, Үйлдвэр 36-52 тоот
Утас	(+976) 99093812

Төслийн байршилтай холбогдох мэдээлэл: Хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай нь Дундговь аймгийн Сайнцагаан, Өлзийт сумдын нутгийг дамнан байрлалтай ба аймгийн төв Мандалговь хотоос урагш 37км, Өлзийт сумын төвөөс хойш 50км орчим зайд, ой, ус, тусгай хамгаалалттай газрын

хуулиар хориглосон бүстэй дахвцалгүй газарт байрлалтай.



Зураг 1.1 Төслийн талбайн байршил

Хүснэгт 2. Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлын цэгүүд

Цэгийн дугаар	Булангийн цэгүүдийн солбицол		Талбайн нэр	Талбайн хэмжээ /га/
	Уртраг	Өргөрөг		
1	106°16'6"	45°24'47"	Уушиг-Уул 1	117.26
2	106°15'20"	45°24'47"		
3	106°15'20"	45°25'25"		
4	106°16'6"	45°25'25"		

Номенклатур: L-48-93



Зураг 1.2 Эдэлбэр газрын төрх байдал



Зураг 1.3 Жоншны илэрцтэй талбайг хашаалсан байдал

1.2. КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.2.1. Уурхайн зохион байгуулалт

Уушиг – Уул уурхай нь Захиргаа аж ахуйн хэсэг, Далд уурхай, Баяжуулах хэсэг, Засвар гэсэн 4 нэгжид нийт 137 хүний ажлын байр бий болно. Уурхайн хэмжээнд уурхайн даргын удирдлага дор Уулын үйлдвэрийн ерөнхий инженер, Баяжуулах хэсгийн ахлах инженер, ерөнхий механик, ХАБЭА -н инженер нар үйлдвэрлэлийн системийг удирдана. Уурхайн бүтэц зохион байгуулалтын ерөнхий хүснэгтийг зураг 1.4, бүтэц орон тооны дэлгэрэнгүйг хүснэгт 1.3.-с харна уу.



Зураг 1.4 Уурхайн бүтэц зохион байгуулалт

Хүснэгт 3. Ажиллах хүчний дэлгэрэнгүй мэдээлэл

№	Албан тушаал	Нийт орон тоо
Захиргаа, аж ахуйн хэсэг		
1	Гүйцэтгэх захирал	1
2	Ерөнхий инженер	1
3	Ерөнхий нягтлан бодогч	1
4	Цахилгааны инженер	1
5	Геологич	2
6	Маркшейдэр	2
7	ХАБЭА-ны инженер	1
8	Байгаль орчны мэргэжилтэн	1
9	Нярав	1
10	Сэлбэг материалын нярав	4
11	Тогооч	2
12	Туслах тогооч	2
13	Үйлчилгээний ажилтан	2
14	Үйлчлэгч, цэвэрлэгч	3
15	Харуул	2
16	Түлшний машины жолооч	1
17	Зам усалгааны машины жолооч	1
Нийт		28
Далд уурхай		
1	Уулын инженер /тэсэлгээний хариуцлагатай удирдагч/	2
2	Маркшейдер	2
3	Уулын мастер	3
4	Нэвтрэгч IV зэрэгтэй	3
5	Нэвтрэгч II зэрэгтэй	6
6	Бэхэлгээчин	3
7	Цахилгаанчин	3

8	Өрөмдөгч IV зэрэгтэй	3
9	Өрөмдөгч II зэрэгтэй	3
10	Зөөвөрлөх машины оператор	18
11	Экскаваторын оператор	12
12	Хийн хангамж, агааржуулалт, насос ажилчид	3
13	Бусад	2
Нийт		63
Баяжуулах хэсэг		
1	Технологич инженер	2
2	Бутлуурын оператор	2
3	Хөдөлмөр хамгааллын ажилтан	2
4	Гар ялгагч	20
Нийт		26
Засвар		
1	Механик инженер	4
2	Гагнуурчин	8
3	Бусад/цахилгаанчин, дугуй засварчин/	8
Нийт		20
НИЙ ДҮН		137

1.3. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ

1.3.1. Ордыг нөөц:

Орд 2 хүдрийн биетээс тогтох ба уг хүдрийн биетүүд нь бие биедээ паралель, уртрагын дагуу сунаж тогтсон, техтоник хагарлын нөлөөгөөр үүсэж Сзмуралын Сахалын гол формацийн хүчиллэг вулканоген хурдас дахь гидротермаль кварц-флюоритын биетүүд юм. Хайгуулын ажлын дүнгээр хүдрийн 2 биет, ил болон далд уурхайн хүрээнд нийт(В+С зэргээр) 110.14 мян.тн хүдэрт 46.39% агуулгатай 51.09 мян.тн хайлуур жоншны нөөц батлагдсан. Батлагдсан нөөцийг ил далд уурхайн хүрээгээр, хүдрийн биет тус бүрээр тооцсоныг дараах хүснэгтэд харуулав.

2019 онд ордын хүдрийн биетүүд дээр гадаргуугаас 39-40 м-ийн тороор суваг малтаж, 35-78 м гүнд баганат өрөмдлөгөөр хайгуулын цооног өрөмдөж, хүдрийн биетүүдийг огтлон, ховилон ба чөмгөн дээж шинжлүүлж, нарийвчилсан хайгуулын ажлыг гүйцэтгэснээр ордыг бүрэн судлагдсан гэж үзэн хүдрийн биетүүдийн хайлуур жоншны нөөцийн тооцоог хийв. Тухайн ордын хүдрийн биетийн агуулга, зузаан нь суналын болон уналын дагуу жигд бус, гүн рүүгээ аажмаар багасдаг зэргээс шалтгаалан уул-геологийн нийлмэл чанараар нь 3-р бүлгийн судлын жижиг ордод хамааруулж авч үзлээ.


“Уушиг-Уул 1” хайлуур жоншны ордын 1, 2-р хүдрийн биетэд бодитой болон боломжит нөөцийг геологийн хэсэгшлийн аргаар тооцжээ.

Ордын хэмжээнд бодитой (В) зэргээр 73.52 мян.тн хүдэрт 48.29%-ийн хайлуур жоншны агуулгатай 35.50 мян.тн хайлуур жонш, боломжтой (С) зэргээр 36.62 мян.тн хүдэрт 47.13%-ийн хайлуур жоншны агуулгатай 17.26 мян.тн хайлуур жонш, бодитой болон боломжтой (В+С) зэргээр 110.14 мян.тн хүдэрт 47.90%-ийн хайлуур жоншны агуулгатай

52.76 мян.тн хайлуур жонш гэж тооцсон байна. Нөөцийн нэгдсэн тооцоог дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 4. Нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт

Д/д	Блокийн дугаар	Жинхэнэ зузаан (м)	Хөндлөн огтлолын талбай (мян.м ²)	Эзлэхүүн (мян.м ³)	Эзлэхүүн жин (тн/м ³)	Хүдрийн хэмжээ (мян.тн)	Дундаж агуулга			Эрдсийн нөөц
							CaF ₂	CaCO ₃	SiO ₂	CaF ₂
							(%)	(%)	(%)	(мян.тн)
Хүдрийн биет I										
1	B-1-1	0.98	19.13	18.74	2.87	53.80	49.63	1.12	38.7	26.70
2	C-1-1	0.96	6.27	6.02	2.87	17.28	48.20	1.09	41.1	8.33
В+С зэргээр		0.98	25.40	24.76	2.87	71.07	49.28	1.11	39.3	35.03
Хүдрийн биет II										
1	B-2-1	1.01	6.80	6.87	2.87	19.72	44.61	1.33	39.5	8.80
2	C-2-1	0.84	8.03	6.74	2.87	19.35	46.17	1.28	42.8	8.93
В+С зэргээр		0.92	14.83	13.61	2.87	39.07	45.38	1.31	41.1	17.73
Ордын хэмжээнд В зэргээр						73.52	48.29	1.18	38.9	35.50
Ордын хэмжээнд С зэргээр						36.62	47.13	1.19	42	17.26
Ордын хэмжээнд В+С зэргээр						110.14	47.90	1.18	40	52.76



Зураг 1.5. Нөөцийн тооцоо


1.3.2. Далд уурхайн хэсэг:

Далд уурхайн одоогийн байдал:

Дундговь аймгийн Сайнцагаан сумын нутагт орших Уушиг уулын уурхайн олборлолтын ажлыг ил уурхайгаар авто тээвэртэй ашиглалтын системээр 2022 оны 10-р сарын 17-ны өдрөөс эхлэн үйл ажиллагааг эхлүүлсэн. 2022 онд 866.43 тн хүдэр, 2023 онд 29,234.28 тн хүдрийг 1272.0-1292.0 м түвшин хооронд олборлолт хийгдэж, 72,870.7 м³ хөрс хуулалт хийж, газрын хэвлийн эвдрэлд ил уурхай 0.9 га, хөрсний гадаад овоолго 1.7 га, шимт хөрсний овоолго 0.09 га, тэсрэх материалын агуулах 1.36 га, хүдэр ялгах хэсэг 0.85 га талбайнууд одоогийн байдлаар өртсөн байна. Мөн II хүдрийн биетийн гарш орчим, ХШ 15, 16 хайгуулын шугам хооронд, 63 м гүнтэй босоо ам нэвтэрсэн бөгөөд тус босоо ам нь далд уурхайн төлөвлөлтийн шилжилтийн бүсийн хүрээнд хамаарч байна. Иймд тус босоо амыг үргэлжлүүлэн ашиглах боломжгүй байна.

Уушиг-Уул 1 ордыг хайгуулын шугам-2, 2-р суваг малталтаас эхэлж гадаад траншейгаар нээсэн ба шимт хөрс болон хөрсийг ил уурхайн зүүн урд хэсэгт байгуулсан. Уурхайн кемп тосгоныг уурхайн баруун талд 450 м зайд байгуулсан ба ажилчдын амьдрах нөхцөл сайжруулах уурхайн бүтээн байгуулалтын ажлыг цаашдаа сайжруулж явахаар төлөвлөж ажиллаж байна.

Уурхайн дотоод болон гадаад замын өргөн 8 м байх ба ажлын талбайн өргөн хамгийн багадаа 9 м байсан ба уурхайн дээд амсрын өргөн 23.3 м, уурхайн ажлын доголын өндөр 5 м, доголын хажуугийн өнцөг 65°, аюулгүй бермийн өргөн 1.0 м өргөнтэй ажилласан байна.



Зураг 1.6. Уурхайн одоогийн байдал



Зураг 1.7. /2022, 2023 онд олборлолтод өртсөн I-р хүдрийн биетийн дагуу зүсэлт/

Уурхайн жилийн хүчин чадал:

Ордын уул-техникийн нөхцөлөөр жилийн хүчин чадлын хэмжээ нь хүдрийн урьдчилсан тооцооны хаягдал ба бохирдлын хэмжээнээс хамаарч 24.1-27.0мян.тн хүдэр болж байна. Дээрх нөхцөлөөр тооцох жилийн дундаж хүчин чадал **25.0 мян.тн** хүдэр болж байна.

Уулын ажлын горим, ашиглах хугацаа:

Далд уурхайн ажиллах горим: Далд уурхайн ажиллах горимыг захиалагч байгууллагаас төсөл боловсруулах даалгаварт тусгагдсаны дагуу дараах байдлаар авч байна. Үүнд:

- Жилийн хуанлийн өдөр 365 хоног
- Баяр ёслолын үеийн амралтын өдөр 12 хоног
- Засвар үйлчилгээний өдөр 53 хоног
- Жилд ажиллах хоног 300 хоног
- Хоногт ажиллах ээлжийн тоо 2 ээлж
- Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа 7 цаг
- Долоо хоногийн ажлын хоног 7 хоног тус тус байна.

“Идэр Макс” ХХК нь 2025 оноос тус ордын далд уурхайг үйлдвэрлэлийн хэмжээнд эзэмших бэлтгэл ажлыг эхэлж УУА, УБА хийх төслийн хүчин чадалд хүрэх болон уурхай бөхөх хугацааны нормоор 25% гэж үзвэл далд уурхайн ашиглах хугацаа **4.3 жил** болж байна.

1.3.3. Уулын малталтуудын хөндлөн огтлолын талбай, уулын хэмжээ:

Ордыг ашиглалтад бэлтгэхэд шаардлагатай уулын малталтууд нь зориулалтаас хамаарч уулын үндсэн, бэлтгэл, огтолгооны гэж ангилагдана.

Уулын малталтуудын хөндлөн огтлолын талбайн хэмжээг түүний зориулалт, уулын даралтын хэмжээ, тоног төхөөрөмжийн овор хэмжээ, агаарын урсгалын хэмжээнээс., малталтын хэлбэрийг уулын даралтын чиглэл, түүний шугаман хэмжээ (тооцооны), бэхэлгээний хийц, ашиглах хугацаанаас зэргээс хамааруулан квершлаг, огтолгооны штрек малталтуудын трапец хэлбэртэй өргөн нь 2.3м өндөр нь 2.27 м тус тус байна. Хүдэр буулгуур нь огтолгооны штрек малталтын тэнхлэгтэй 90°-ийн өнцөг үүсгэн огтлолцохоор нэвтэрсэн байна. Хүдэр буулгууруудын хоорондын зай нь 7 м-ээс багагүй байх бөгөөд ашиглалтын нэг блокт 6 хүдэр буулгуур байна. Восстающний цонх малталтаас хүдрийн суналын дагуу S=4.0 м² хөндлөн огтлолын талбайтай штрек малталт нэвтрэх ба хамгаалалтын цулыг огтолгооны штрекнээс 4м-ийн зайтай үлдээж нэвтэрнэ. Үүний дараагаар огтлогч малталтыг нэвтэрснээр олборлолт нураалтын ажлыг эхлүүлнэ. Уурхайн үндсэн болон бэлтгэл бүх малталтуудын хөндлөн огтлолын

талбайг тодорхойлж, уулын ажлын хэмжээ, өрөмдлөг тэсэлгээний ажил, паспортуудыг хавсралт зурагт тус тус үзүүлэв.

Хүснэгт 5. Уушиг уулын далд уурхайн уулын ажлын хэмжээ

Малталтын нэр	Урт, м	Хөндлөн огтлолын талбай, м ²	Ажлын хэмжээ, м ³			Ажлын төрөл
			Нийт	Үүнээс		
				хүдэрт	агуулагч чулуулагт	
1-р хүдрийн биет						
1233.55-1277.1м түвшний уулын ажил						
Налуу гол ам	221.5	5.28	1169.5	0	1169.5	УҮА
Квершлаг	21	5.28	110.9	0	110.9	УҮА
Тээврийн штрек	325.4	5.28	1718.1	0	1718.1	УБА
Огтолгооны штрек	317	5.28	1673.8	753.2	920.6	УОА
Восстающий	336	5.2	1747.2	872.9	714.2	УОА
Блокийн цонх	219	4	876.0	433.3	385.1	УОА
Ачилтын орт	180	5.28	950.4	285.1	665.3	УБА
Хэвтээ ходок	35	5.28	184.8	55.4	129.4	УБА
Зумпф	20	7.9	158.0	0	158	УҮА
Хүдэр буулгуур	144	4	576.0	259.2	316.8	УБА
Хайгуулын орт	21	5.28	110.9	0	110.9	ГХА
Нийт	1839.9		9275.6	2659.1	6398.8	
Үүнээс: уулын үндсэн ажил	262.5		1438.4	0	1438.4	УҮА
уулын бэлтгэл ажил	684.4		3429.3	599.7	2829.6	УБА
уулын огтолгооны ажил	872.0		4297.0	2059.4	2019.9	УОА
геологи хайгуулын ажил	21.0		110.9	0.0	110.9	ГХА
1190.0-1233.55м түвшний уулын ажил						
Налуу гол ам	186.1	5.28	982.608	0	982.6	УҮА
Квершлаг	17	5.28	89.76	0	89.8	УҮА
Тээврийн штрек	273.7	5.28	1445.14	0	1445.1	УБА
Огтолгооны штрек	265	5.28	1399.2	629.6	769.6	УОА
Восстающий	261.6	5.2	1360.32	748.2	612.1	УОА
Блокийн цонх	180	4	720	194.4	237.6	УОА
Ачилтын орт	150	5.28	792	237.6	554.4	УБА
Хэвтээ ходок	30	5.28	158.4	47.5	110.9	УБА
Зумпф	20	7.9	158	0	158	УҮА
Хүдэр буулгуур	120	4	480	216	264	УБА
Хайгуулын орт	18	5.28	95.04	0	95	ГХА
Нийт	1521.40		7680.46	2073.30	5319.10	
Үүнээс: уулын үндсэн ажил	223.10		1230.37	0.00	1230.40	УҮА
уулын бэлтгэл ажил	573.70		2875.54	501.10	2374.40	УБА
уулын огтолгооны ажил	706.6		3479.52	1572.2	1619.3	УОА
геологи хайгуулын ажил	18		95.04	0	95	ГХА
2-р хүдрийн биет						
1224.5-1277.52 м түвшний уулын ажил						
Квершлаг	95	5.28	501.6	0	501.6	УҮА
Тээврийн штрек	270	5.28	1425.6	0	1425.6	УБА
Огтолгооны штрек	265	5.28	1399.2	629.6	769.6	УОА
Восстающий	402	5.2	1653.6	909.5	744.1	УОА
Блокийн цонх	282	4	504	226.8	277.2	УОА
Ачилтын орт	150	5.28	792	237.6	554.4	УБА

Хэвтээ ходок	30	5.28	158.4	47.5	110.9	УБА
Зумпф	20	7.9	158	0	158	УУА
Хүдэр буулгуур	120	4	480	216	264	УБА
Хайгуулын орт	18	5.28	95	0	95	ГХА
Нийт	1652		7167.4	2267	4900.4	
Үүнээс: уулын үндсэн ажил	115		659.6	0	659.6	УУА
уулын бэлтгэл ажил	570		2856	501.1	2354.9	УБА
уулын огтолгооны ажил	949		3556.8	1765.9	1790.9	УОА
геологи хайгуулын ажил	18		95	0	95	ГХА
Уулын ажлын нэгдсэн дүн						
Налуу гол ам	407.6	5.28	2152.1	0	2152.1	УУА
Квершлаг	133	5.28	702.2	0	702.2	УУА
Тээврийн штрек	869.1	5.28	4588.8	0	4588.8	УБА
Огтолгооны штрек	847	5.28	4472.2	2012.5	2459.7	УОА
Восстающий	999.6	5.2	5197.9	2530.5	2667.4	УОА
Блокийн цонх	681	4	2724.0	1225.84	1498.16	УОА
Ачилтын орт	480	5.28	2534.4	760.3	1774.1	УБА
Хэвтээ ходок	95	5.28	501.6	150.5	351.1	УБА
Зумпф	60	7.9	474.0	0	474	УУА
Хүдэр буулгуур	384	4	1536.0	691.2	844.8	УБА
Хайгуулын орт	57	5.28	301.0	0	301	ГХА
Нийт	5013.3		25184.3	7370.8	17813.4	25184.20
Үүнээс: уулын үндсэн ажил	600.6		3328.37	0.0	3328.3	УУА
уулын бэлтгэл ажил	1828.1		9160.85	1602.0	7558.8	УБА
уулын огтолгооны ажил	2527.6		12394.1	5768.8	6625.3	УОА
геологи хайгуулын ажил	57		300.96	0.0	301.0	ГХА

1.4. БАЯЖУУЛАХ ТЕХНОЛОГИ

“Идэр Макс” ХХК нь “Ханлаб” ХХК-ий лабораторид ордын технологийн туршилтыг хийж гүйцэтгүүлсэн байна. Тухайн орд нь нөөц багатай, гидрогеологийн нөхцөл хүнд тул флотацийн баяжуулах үйлдвэр байгуулахад эдийн засгийн хувьд ашиггүй юм. Иймд баяжуулалтын технологийг гар аргаар ангилан ялгах аргаар сонгов.

Технологийн туршилт судалгаагаар тухайн ордын хүдрийг нэг шатны бутлуураар бутлан чичиргээт шигшүүрээр шигшин ангилж, бутлагдсан хүдрийг нэгэн жигд ширхэглэл бүхий фракцуудад хуваан гар аргаар ангилан ялгах бүрэн боломжтой нь тогтоогдсон.

Захиалагчаас ирүүлсэн төслийн даалгавар болон технологийн туршилтын үр дүнд үндэслэн жоншны хүдэр ялган ангилах тоног төхөөрөмж, технологийн сонголтыг хийсэн бөгөөд тус ордын жоншны хүдрийг гар аргаар ялгаж, ФК-75 маркийн бүхэллэг жонш гарган авах технологийг боловсрууллаа. Анхдагч хүдрийг уурхайн талбайд ангилан баяжуулж, хоосон чулуулаг ялгаж, тээвэрлэх хүдрийн хэмжээг бууруулах замаар төслийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх бодит боломжийг бүрдүүлэх юм.

Уурхайгаас ирсэн хүдрийн овоолгоос ангилан ялгах цехэд дугуйт ачигчаар хяналтын 300 мм нүхтэй гулдмай шигшүүртэй бункерийг ачаална. Хүдэр бункерээс анхан шатны бутлуур руу өгөгдөх бөгөөд бутлагдсан хүдэр ялтсан тэжээгүүрийн тусламжтайгаар чичиргээт шигшүүрт өгөгдөн 60 мм ширхэглэлээр ангилагдана. Шигшүүрээс гарах бүтээгдэхүүн тус бүрийг туузан дамжуулгаар


тээвэрлэгдэн шигшүүрийн дээд бүтээгдэхүүн болох +60 мм-ийн ангийг гар ялгалтаар ялгана.

Гар ялгалтаас үлдсэн бага агуулгатай хүдрийг шигшүүрийн доод бүтээгдэхүүн болон -60 мм-ийн ангийн бүтээгдэхүүнтэй холилт хийн ойролцоох баяжуулах үйлдвэрт нийлүүлнэ. Ингэснээр баяжуулах хэсгээс хаягдал гарахгүй бөгөөд олборлосон бүх хүдрийг экспортын болон дотоодын борлуулалт хийн эдийн засгийн эргэлтэд оруулна.

Жоншны хүдрээс гар аргаар ялган авсан таваарын баяжмалын агуулга 75% байхаар бодож бүтээгдэхүүний балансыг тооцлоо.

Цаашид гар ялгалтаар ялгах процессыг хөнгөвчлөн ангилах төхөөрөмжөөр баяжуулалтын явуулахыг төсөл зохиогчдоос санал болгож байна. Мөн олборлолт, баяжуулалтын үед чанар болон технологийн хяналт, сорьцлолтын ажлыг тогтмол хийхийг төсөл хэрэгжүүлэгч компанид зөвлөмж болгож байна.

Гар аргаар ангилан ялгах технологийн схемийг дараах зурагт үзүүлэв.



Зураг 1.8. Гар аргаар ялган ангилах цехийн технологийн схем

Уурхайгаас нийлүүлэгдэх хүдрийг (<300мм) хацарт бутлуураар 75 мм хүртэл бутлан, бутлагдсан хүдрийг чичиргээт шигшүүрээр шигшин шигшүүрийн доод бүтээгдэхүүнийг буюу -60 мм ангиллын фракцыг үлдэгдэл хүдрийн овоолгод зөөвөрлөн хураана. Шигшүүрийн дээд +60 ангиллын бүтээгдэхүүнийг гар ялгалт хийн ФК-75 маркийн бүхэллэг жонш гарган авах ба ялгалтаас үлдсэн бага агуулгатай хүдрийг -60 мм ангиллын хүдрийн овоолгод хураана.

1.4.1. Хүдэр ангилах хэсгийн ажиллах горим, хүчин чадал

“Уушиг-Уул 1” нэртэй хайлуур жоншны ордыг далд уурхайн аргаар ашиглах ба ашиглалтын жил бүр ангилан ялгах цехэд нийлүүлэх хүдрийн хэмжээ болон дундаж агуулгыг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 6. Далд уурхайгаас ангилан ялгах цех-д нийлүүлэх хүдрийн хэмжээ болон агуулга

Ашиглалтын жил	Ашиглалтын нөөц		
	Хүдэр, тн	CaF2 агуулга, %	Эрдэс, тн
I-р жил	10,000	47.91	4,791
II-р жил	25,000	46.02	11,505
III-р жил	25,000	46.24	11,559
IV-р жил	15,721	46.62	7,329
НИЙТ	75,721	46.46	35,183

Ангилан ялгах цехийн хүчин чадлыг төсөл захиалагчаас ирүүлсэн техникийн даалгаварт санал болгосны дагуу болон уулын ажлын хүчин чадалтай уялдуулж жилд 25.0 мян.тн хүдэр ангилан ялгах аргаар төлөвлөлөө. “Идэр Макс” ХХК-ийн “Уушиг-Уул 1” хайлуур жоншны ангилан ялгах цех нь улирлын чанартай ажиллах бөгөөд бүрэн хүчин чадлаараа ажиллахад хавар 4 дүгээр сарын эхнээс намар 10 дугаар сарын сүүл хүртэл жилд 185 хоног орчим ажиллана. Ангилан ялгах цех нь хоногт 9 цагийн 1 ээлжээр ажиллана. Цехийн ажиллах горимын тооцоог дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 7. Баяжуулах хэсгийн ажиллах горимын тооцоо

№	Үзүүлэлт	Тоо хэмжээ			
		I-р жил	II-р жил	III-р жил	IV-р жил
1	Төслийн жилийн хуанлийн нийт өдөр	74	185	185	118
2	Жилд ажиллах сар	3	7	7	5
3	Ээлжийн үргэлжлэх хугацаа	9	9	9	9
4	Ээлжийн тоо	1	1	1	1
5	Сард хийгдэх засвар үйлчилгээний цаг	5	5	5	5
7	Сард ажиллах бодит хоног	25	25	25	25
8	Жилд ажиллах цаг	1778	4444	4444	2829
9	Цаг ашиглалтын коэффициент, %	0.9	0.9	0.9	0.9
10	Жилд ажиллах бодит цаг	667	1667	1667	1061
11	Цагийн хүчин чадал, тн/цаг	15	15	15	15
12	Хоногийн хүчин чадал, тн/хоног	135	135	135	135
13	Сарын хүчин чадал, тн/сар	3375	3375	3375	3375
14	Жилд ангилах хүдрийн хэмжээ, тн	10000	25000	25000	15721

1.4.2. Бүтээгдэхүүн гаргалт

Далд уурхайгаас ирэх хүдрийг гар ялгалтаар ялган ФК-75 маркийн металлургийн бүхэллэг жонш болон 27.76 хувь СаF₂-ын агуулга бүхий бага агуулгатай хүдэр гарган авах технологийг сонгосон. Төслийн нийт хугацаанд 29.98 мян.тн экспортын баяжмал, 45.74 мян.тн бага агуулгатай хүдрийг дотоодын борлуулалтаар борлуулна. Металлургийн бүхэллэг жоншийг шууд БНХАУ-руу экспортод гаргах бол бага агуулгатай хүдрийг ойролцоох жоншны баяжуулах үйлдвэрт борлуулна. Төслийн талбайгаас ойролцоогоор 100 гаруй км зайд Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Болор жонш” ХХК-ий жоншны баяжуулах үйлдвэр байдаг. Тус үйлдвэр нь ойролцоох ордуудаасаа бага агуулгатай хүдэр худалдаж авч флотацийн аргаар баяжуулдаг үйлдвэр юм. Мөн төслийн талбайгаас урагш Дорноговь аймагт Өндөршил болон Айраг сумуудад жоншны баяжуулах үйлдвэрүүд байдаг. Иймд бага агуулгатай хүдрээ тухайн баяжуулах үйлдвэрүүдэд борлуулах боломжтой. Бүтээгдэхүүн гаргалтын тоо хэмжээг жил жилээр үзүүлснийг хүснэгт 8-д үзүүллээ.

Хүснэгт 8. Бүтээгдэхүүн гаргалтын тооцоо /Жил бүрээр/

Үзүүлэлт	Хэмжих нэгж	НИЙТ	АШИГЛАЛТЫН ЖИЛ			
			1дэх жил	2дэх жил	3 дахь жил	4 дахь жил
Далд уурхайгаас олборлох хүдэр	тн	75,721	10,000	25,000	25,000	15,721
Хүдрийн агуулга, %	%	46.46	47.91	46.02	46.24	46.62
Жилд ажиллах хоног	хон	560.90	74.07	185.19	185.19	116.45
Хоногт ажиллах цаг	цаг	9.00	9.00	9.00	9.00	9.00
Жилд ажиллах нийт цаг	цаг	5,048	667	1,667	1,667	1,048
Цагийн бүтээл	тн/цаг	15.00	15.00	15.00	15.00	15.00
Хүдэр боловсруулалт	тн	75,721	10,000	25,000	25,000	15,721
Баяжмал гаргалт	тн	29,978	3,959	9,898	9,898	6,224
Баяжмалын агуулга	%	75.00	75.00	75.00	75.00	75.00
Баяжмалын гарц	%	39.59	39.59	39.59	39.59	39.59

Баяжмалын эрдэс авалт	%	64.41	64.99	63.56	63.72	64.02
Бага агуулгатай хүдэр	тн	45,743.1	6,041	15,103	15,103	9,497
Бага агуулгатай хүдрийн агуулга	%	27.76	27.76	27.76	27.76	27.76
Бага агуулгатай хүдрийн гарц	%	60.41	60.41	60.41	60.41	60.41
Бага агуулгатай хүдрийн эрдэс авалт	%	36.10	35.01	36.44	36.28	35.98

1.4.3. Тоног төхөөрөмж сонголтын тооцоо

Уурхай нь жилд олборлох үйлдвэрлэлийн нөөц нь 25.0 мян.тн, 46.46% агуулгатай хүдрийг буталж шигшиж, шигшүүрийн дээд ангиллын жоншны хүдрийг гар аргаар ялгахаар тооцоолсон. Гар ялгалтад туузан ба ялтсан конвейер, бутлуур, чичиргээт шигшүүр зэрэг төхөөрөмжүүдийг ашиглана. “Идэр Макс” ХХК гар аргаар ангилах цехийн тоног төхөөрөмжүүдийг шинээр худалдаж авна.

1.4.4. Талбай тоос дарах технологи

Бутлуурын хэсэгт хамгийн их тоос үүснэ. Иймд тус хэсэгт үүсэх тоосыг манантуулагч буу ашиглан тоосжилтыг бууруулахаар төсөлд тусгалаа.

Манантуулагч буу:

Манантуулагч нь усыг маш нарийн ширхэгтэйгээр агаар цацдаг усан буу юм. Агаарт дэгдэх тоосонцор руу цацсанаар тухайн хэсэгт үүсэх нарийн тоосыг манан хэлбэрийн усны дуслууд барьж буулгана. Манантуулагч нь 40° хэлбэлзэлтэйгээр 100м хүртэл өндөр хүртэл манан үүсгэх давуу талтай. Усны зарцуулалт бага хэлбэлзлийн хүрэнээс хамаарч 4.9-9.8 л/мин байна. Хоногт 18 цаг тасралтгүй ажиллуулахад 43.2 м³ ус зарцуулна. Стандарт 70° налуутай манантуулахад 0.2 га талбайг тосгуйжүүлнэ. Манантуулагч бууг дараах зурагт харуулав. Тоос дарах усны зарцуулалтын хэмжээг дэлгэрэнгүй орууллаа.



Зураг 1.9. Манантуулагч буу

1.5. ТӨСЛИЙН ДЭД БҮТЭЦ

Ордын ерөнхий төлөвлөгөөний шийдэл Дундговь аймгийн Сайнцагаан, Өлзийт сумдын нутагт дэвсгэрт орших MV-005210 тоот лицензийн талбай дотор, төв хэсэгт талбайн аль ч хэсэгт хамгийн бага зам, хугацаа зарцуулж хүрэх зам харилцаа болон ашиглалт явагдах хэсэгт ойр байх, объектуудын хоорондох хамгийн бага байж болох зөвшөөрөгдөх норматив, шаардлагуудыг тусгаж төлөвлөв.

Тус уурхай нь дараах хэсгүүдээс бүрдэнэ:

- ✓ Хайлуур жоншны хүдэр олборлох далд уурхай
- ✓ Захиргаа болон ажиллагсдын түр орон сууц
- ✓ Цахилгаан хангамж
- ✓ Усан хангамж
- ✓ Засвар механикийн хэсэг /токарийн машин болон өрмийн цахилгаан машин, бусад шаардлагатай багаж хэрэгслүүд/
- ✓ Хоолны газар /вагончик/

- ✓ Тэсрэх материалын агуулах
- ✓ Уурхайн авто зам зэрэг объектууд багтана.

1.5.1. Талбай тоос дарах технологи

Далд уурхайн талбайн хүрээнд ашиглалтад бэлтгэх ажлууд болон налуу гол амны бэхэлгээнүүдийг тоноглох, үндсэн малталт нэвтрэх, хоосон чулуулгийн ба хүдрийн овоолгуудыг байгуулах зэрэг ажлууд явагдана.

- ✓ Далд уурхайн налуу гол ам
- ✓ Агааржуулалтын восстающий малталтууд
- ✓ Хайлуур жоншны хүдрийн овоолго
- ✓ Хоосон чулуулгийн овоолго
- ✓ Уурхайн дотоод зам

Далд уурхайг ашиглаж дууссан тохиолдолд газрын гадаргад ил гарсан малталтуудын амуудыг бетондон хааж анхааруулах тэмдэг байрлуулах ба бусад холбогдох арга хэмжээг авна. Энэ нь ашиглалт дуусах үед төлөвлөсөн нэмэлт зардлаар шийдэгдэнэ. Эдгээр овоолго заавал уурхайн эдэлбэр болох ба 28.1 га талбай дотор байрласан байх шаардлагатай.

1.5.2. Уурхайн усан хангамж

Усны эх үүсвэр:


Төслийн талбайн унд – ахуйн болон баяжуулах хэсгийн тоос дарах усны хэрэглээ одоо ашиглаж байгаа өрөмдмөл худгаас хангахаар тусгав. Өрөмдмөл худаг нь төслийн талбайгаас 100 м зайд, уурхайн хотхоноос 400 м оршиж байгаа бөгөөд худгаас усны машинаар зөөвөрлөн хангана. Тус худгийн усанд хийгдсэн химийн шинжилгээгээр магни болон хлоридын агуулга зөвшөөрөгдсөн дүнгээс өндөр гарсан байна. Иймд өрөмдмөл худгийн усыг унд ахуйн хэрэглээнд ашиглахдаа нэмэлт ус цэвэршүүлэгч төхөөрөмж байрлуулснаар хэрэглээнд ашиглахаар тусгалаа.

Уурхайн өрмийн машинд хэрэглэх ус болон гадна талбайн тоос дарах усны хэрэглээг далд уурхайн шүүрлийн усыг хуримтлуулан ашиглахаар төлөвлөв. Өрөмдмөл худгийн байрлал болон шүүрлийн ус цуглуулах даланг дараах зурагт үзүүлээ. Өрөмдмөл худгийн техникийн мэдээллийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 9. Өрөмдмөл худгийн үзүүлэлт

№	Худгийн нэр	Худгийн координат	Байршил	Ашиглалтын ундраг, л/с	Насосын марк
1	Well-1	106°16'00" 45°25'34"	Дундговь аймаг Мандал-Овоо сум, Цавтын шанд	1.0	QJ-100

⊕ ӨРӨМДМӨЛ
ХУДАГ



Зураг 1.10. Ус хангамжийн цэгүүдийн байршил

Усны хэрэглээ:

Төслийн талбайд дараах шаардлагаар усны хэрэглээ үүснэ. Үүнд:

1. Ажилчдын унд, ахуйн усны хэрэглээ
2. Баяжуулах цехийн тоос дарах усны хэрэглээ
3. Далд уурхайн усны хэрэглээ

Ажилчдын унд, ахуйн усны хэрэглээ болон баяжуулах хэсгийн тоос дарах усны хэрэглээг цэвэр усаар хангах бол далд уурхайн усны хэрэглээг далд уурхайн шүүрлийн усаар шийдвэрлэхээр төсөлд тусгав. Зөөврөөр ашиглах усны хэрэглээг дараах байдлаар тооцоолов. Ингэхдээ баяжуулах хэсэг болон далд уурхайн ажиллах хоног өөр тул тус тусад нь тооцоолов.

Хүснэгт 10. Уурхай болон хотхоны ажилчдын унд, ахуйн усны хэрэглээ

№	Ус ашиглах зориулалт	Уурхай болон хотхон		Ус ашиглах стандарт (L/хүн·хоног)	Унд ахуйн усны хэрэглээ	
		Байнга ажиллах хүний тоо	Жилд ажиллах хоног		Өдөрт ашиглах усны хэмжээ (м³/хон)	Жилд ашиглах усны хэмжээ (м³/жил)
1	1-р жил	63	300	150	9.15	2,745.00
2	2-р жил	63	300	150	10.35	3,105.00
3	3-р жил	63	300	150	10.35	3,105.00
4	4-р жил	63	300	150	10.35	3,105.00
						12,060.00

Хүснэгт 11. Баяжуулах хэсгийн ажилчдын унд, ахуйн усны хэрэглээ

№	Ус ашиглах зориулалт	Баяжуулах хэсэг		Ус ашиглах стандарт (L/хүн·хоног)	Унд ахуйн усны хэрэглээ	
		Ажиллах хүний тоо	Жилд ажиллах хоног		Өдөрт ашиглах усны хэмжээ (м³/хон)	Жилд ашиглах усны хэмжээ (м³/жил)
1	1-р жил	11	74	150	1.95	144.44
2	2-р жил	11	185	150	1.95	361.11
3	3-р жил	11	185	150	1.95	361.11
4	4-р жил	11	116	150	1.95	227.08
						1,093.75

Хүснэгт 12. Баяжуулах хэсгийн тоос дарах усны хэрэглээ

№	Ашиглалтын жил	Тоос дарах төхөөрөмжийн усны зарцуулалт, л/мин	Цагт ашиглах усны хэмжээ (м³/цаг)	Жилд ажиллах цаг	Жилд ашиглах усны хэмжээ (м³/жил)
1	1-р жил	4.90	0.29	222	65.33
2	2-р жил	4.90	0.29	556	163.33
3	3-р жил	4.90	0.29	556	163.33
4	4-р жил	4.90	0.29	349	102.71
					494.71

Хүснэгт 13. Төслийн нийт усны хэрэглээ

№	Усны зардал	Хэмжих нэгж	Ашиглалтын жил				Нийт
			1	2	3	4	
ӨРӨМДМӨЛ ХУДГААС ХАНГАХ УСНЫ ХЭРЭГЛЭЭ							
1	Баяжуулах хэсгийн усны хэрэглээ /тоос дарах/	м³	65.33	163.3	163.3	102.7	494.7
2	Далд уурхай болон хотхоны ажилчдын унд ахуйн хэрэглээ	м³	2,745.00	3,105.0	3,105.0	3,105.0	12,060.0

3	Баяжуулах хэсгийн ажилчдын унд ахуйн хэрэглээ	м ³	144.44	361.1	361.1	227.1	1,093.7
Нийт усны хэрэглээ		м ³	2,954.8	3,629.4	3,629.4	3,434.8	13,648.5
4	Хоногт хэрэглэх усны хэмжээ	м ³	9.85	12.10	12.10	11.45	
5	Шаардагдах усны ундрага	л/с	0.12	0.14	0.14	0.14	
ШҮҮРЛИЙН УСНЫ ДАЛАНГААС ХАНГАХ УСНЫ ХЭРЭГЛЭЭ							
1	Өрөмдлөгийн үед шпур угаах усны хэрэглээ	м ³	432.00	432.0	432.0	432.0	1,728.0
2	Чулуулгийг тэслэх үед тоос дарахад зориулсан усны хэрэглээ	м ³	17.10	17.1	17.1	17.1	68.4
3	Чулуулгийг ачих үед тоос дарахад зориулсан усны хэрэглээ	м ³	19.38	19.4	19.4	19.4	77.5
Нийт усны хэрэглээ		м ³	468.5	468.5	468.5	468.5	1,873.9
4	Хоногт хэрэглэх усны хэмжээ	м ³	1.56	1.56	1.56	1.56	
5	Шаардагдах усны ундрага	л/с	0.02	0.02	0.02	0.02	

Төслийн нийт хугацаанд өрөмдмөл хурдгаас 0.2 л/с ундарга шаардлагатай байна. Шүүрлийн далангаас ашиглах усны хэрэглээ 0.02 л/сек байна.

Цахилгаан хангамж

Уурхайн цахилгаан хэрэглэгчдийг төвлөрсөн цахилгаан хангамжаас эрчим хүчээр хангах боломжгүй учир дизель цахилгаан үүсгүүрээс цахилгаан эрчим хүчээр хангахаар төсөлд тусгаж байна. Далд уурхай болон хотхоны дэргэд 300кВА-ын 1 ширхэг дизель станц байрлуулж цахилгаан эрчим хүчээр хангана.

Уурхайн цахилгаан хэрэглэгчид:

Тус хайлуур жоншны ордыг ашиглах далд уурхайн цахилгаан хэрэглэгчид нь:

- Далд уурхайн газрын дээр ажиллах цахилгаан хэрэглэгчид (*ерөнхий агааржуулалтын суурин сэнс, компрессор*)
- Далд уурхайн газрын доор ажиллах цахилгаан хэрэглэгчид (*зөөврийн сэнс, ус зайлуулах шахуурга, газар доорх засварын цех далд уурхайн гэрэлтүүлэг*)
- Уурхайн тосгон (*Ажилчдын байр, уурхайн захиргаа, халуун ус, хоолны газар, уурын зуух*)
- Засварын газар бусад хэрэглэгчид (*Засварын газар, шатахуун түгээх станц, сэлбэгийн агуулах*) байх бөгөөд тэдгээрийг цахилгаан эрчим хүчээр хангах шаардлагатай.

Уурхайн цахилгаан хэрэглэгчдийн суурилагдсан чадал нь ордын ашиглалтын нөөц, ордын байршил, уул техникийн нөхцөл, далд уурхайн хүчин чадал, уурхайн ус таталт, үйлдвэрлэлийн процессын механикжуулалт зэргээс хамаарч байдаг.

Уурхайн гэрэлтүүлэг:

Далд уурхайд хэрэглэгдэх гэрэлтүүлэх хэрэгсэл нь хэрэглэгдэх нөхцөлөөс хамаарч хий тоосны аюулгүй уурхайд хэрэглэдэг хэвийн хийцтэй РВЛ-80 маркийн гэрэлтүүлэгчийг 8м зайтайгаар угсарч хүчдэл нь 127В-оос ихгүй байна.

Хүснэгт 14. РВЛ-80 маркийн гэрэлтүүлэгчийн техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоон утга
1	Гэрэлтүүлэгчийн төрөл		РВЛ-80
2	Заасан хүчдэл	В	127
3	Чийдэнгийн чадал	Вт	80

4	Чийдэнгийн гэрлийн урсгал	Лм	3840
5	Гэрэлтүүлэгчийн а.ү.к	%	60
6	Хамгаалалтын түвшин	РП	
7	Гэрэлтүүлэгчийн жин	кг	1.55

Зам тээвэр, харилцаа холбоо:

Уурхай нь ойролцоох төв суурин газруудтай ердийн хээрийн орон нутгийн чанартай шороон замаар холбогдоно. Төслийн талбайн дотоод замууд нь байнга усалгаа арчилгаатай уурхайн зориулалтай шороон зам байна. Харин далд уурхайгаас олборлосон хайлуур жоншны хүдрээс гар аргаар ялгасан металлургийн баяжмал болох ФК-75 маркийн бүхэллэг жонш болон үлдэгдэл бага агуулгатай хүдрийг Чойр хүртэл авто тээврээр тээвэрлэж, түүнээс цааш төмөр замаар экспортод гаргаж борлуулан.

Уурхайн ойролцоох төв суурин газрууд нь харилцаа холбоо дунд зэрэг хөгжсөн бүсэд хамрагдана.

Уурхайн үйл ажиллагаа, зохион байгуулалт, хяналтын үүргийг 24 цагийн турш диспетчер хариуцаж ажиллана. Диспетчерийг уурхайд үйл ажиллагаа явуулж буй бүх нэгж, хэсэгтэй холбогдох харилцаа холбоогоор хангасан байна.

Уурхайн барилга байгууламжууд:

Ажиллагсдын тосгон болон уурхайн захиргаа зэргийг уурхайгаас баруун хойд зүгт 1км зайд барьж байрлуулна. Мөн уурхайн захиргаа, үйлчилгээний байруудыг үйлдвэрийн объектуудын дэргэд барина. Энд захиргааны ажилтнуудын контороос гадна хоолны газар, халуун ус, эмнэлгийн цэгийг байрлуулна.



Зураг 1.11. Хоолны газар



Зураг 1.12. Ажилчдын амрах байр



Зураг 1.13. Уурхайн инженер техникийн ажилчдын ажлын өрөө

Хэдийгээр тус уурхайд тэргүүний дэвшилтэт технологитой, өндөр бүтээмжтэй тоног төхөөрөмж ажиллах боловч ажиллагсдын ажиллаж амьдрах тав тухтай нөхцөлийг бүрдүүлэхгүйгээр хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, тавьсан зорилгодоо хүрэх боломжгүй юм. Ийм учраас уурхайн үйлдвэрийн болон технологийн ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх нь тэргүүн зэргийн зорилтын нэг болно. Энэ зорилтыг хэрэгжүүлэхэд дараах багц асуудлыг авч үзэх хэрэгтэй. Үүнд:

- Хөдөлмөрийн хөлс
- Орон сууцны нөхцөл
- Ахуйн үйлчилгээ
- Эмнэлгийн үйлчилгээ

Эрүүл мэндийн урьдчилсан үзлэг хийх, зөвлөгөө өгөх, ойр зуурын өргөн хэрэглээний эмийн сан бүхий цэг, эмчийн хувьд уурхай дээр орон тооны 1 бага эмч ажиллана. Уурхайн газрын дээрх барилга байгууламж, уурхайн удирдлагуудын контор буюу ажлын өрөө, нярадын байр буюу даалгавар авах өрөө, ажилчдын хувцас солих, усанд орох газар, уурхайн ажиллагсдын цайны газар, авто машины засварын газар зэрэг барилга байгууламж нь уурхайн тосгон дотор байрлана. Шатахуун түгээх станц нь уурхайн тосгон болон бусад барилга байгууламжаас аюулгүйн зайг тус тус харгалзан барьж байгуулна. Уурхайн газрын дээрх барилга байгууламж, уурхайн удирдлагуудын контор буюу ажлын даалгавар авах өрөө, ажилчдын хувцас солих, усанд орох газар, уурхайн ажиллагсдын цайны газар, засварын газар зэрэг барилга байгууламж нь уурхайн тосгонд байрлана. Тэсрэх бодис болон тэсэлгээний хэрэгсэл хадгалах түр агуулах, шатахуун түгээх станц зэрэг нь уурхайн тосгон болон бусад барилга байгууламжаас аюулгүйн зайг тус тус баримтлан алслагдсан зайд байгуулна.

Засвар техникийн үйлчилгээ:

Уурхайн тоног төхөөрөмжийн засвар, техникийн үйлчилгээний газар нь уулын механик тоног төхөөрөмж, авто тээврийн болон бусад тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангахын тулд урсгал засвар, техникийн үйлчилгээ хийх, ашиглалт засварын хэрэгцээнд зориулсан материал, сэлбэг, тос, түлш зэргийг хүлээн авах, хадгалах зэрэг ажлыг гүйцэтгэнэ.


Тоног төхөөрөмжийн их засвар, зарим нарийн төвөгтэй эд ангийг сэргээх, бүрэн солих зэрэг ажлыг засварын дагнасан газраар буюу тоног төхөөрөмжийг нийлүүлсэн газрын засварын газраар гүйцэтгүүлэн. Засварын газар нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

- Уулын механик тоног төхөөрөмжийн агрегат ба автомашины засвар, техникийн үйлчилгээний хэсэг
- Механик цех
- Цахилгаан тоноглолын засварын хэсэг
- Шингэн түлшний резервуар, түгээх цэг
- Материал, сэлбэгийн агуулах

- Автомашины гараж

Хүнд машин механизмын засвар механикийн цех: Уурхайн тосгоны дэргэд байрлах хүнд машин механизмын тоног төхөөрөмжийг засварлах, хуучин сэлбэгийг сэргээн засварлах, урсгал засварын ажлыг хийж гүйцэтгэхэд оршино. Нэгдсэн засварын цехийн тоног төхөөрөмжүүдийн засвар үйлчилгээнд шаардагдах тоног төхөөрөмжийг иж бүрнээр сонгосон байна. Үүнд:

- Токарийн суурь машин
- Өндөр даралтын шланк базагч
- Өрмийн суурь машин
- Суурин гидро насос
- Суурин точил
- Аккумулятор цэнэглэгч
- Гагнуурын аппарат
- Хийн гагнуур
- Керосин зүсүүр тус тус байна.



Зураг 1.14. Засварын газрын сандвичийн барилга

Далд уурхайд ажиллах техник тоног төхөөрөмжүүдийн засвар үйлчилгээг хийх зориулалт бүхий засварын газар нь налуу гол амны дэргэд байрлана. Далд уурхайн засварын газарт өргөх төхөөрөмж, токарь болон өрмийн цахилгаан суурь машин, гагнуурын аппарат, багаж хэрэгсэл байна. Уурхайн газрын дээр ажиллах техник тоног төхөөрөмжүүдийн бүрэн бүтэн байдлыг хангаж тэдгээрийн засвар үйлчилгээг ХАБЭА-н нэгдсэн дүрмийн дагуу зориулалтын байр болон зогсоолын газарт цаг алдалгүй хийх шаардлагатай байдаг.

Тэсрэх материалын болон шатах тослох материалын агуулах:

10 тонны багтаамжтай тэсрэх материалын агуулахыг үйлдвэрлэлийн цогцолбороос 0.5 км-ээс багагүй зайд барьж байгуулна.

Сэлбэг материалын агуулахыг 40 тн багтаамжтай контейнерт байршуулсан бөгөөд зарим овор ихтэй тоног төхөөрөмж, машин механизмын сэлбэгийг зориулалтын талбайд саравч амбаар зэрэгт хадгалж байна. Шатах, тослох материалын агуулах нь торон хашаагаар хүрээлэгдсэн задгай талбайд үйлдвэрлэлийн цогцолбороос 200 метрээс доошгүй зайд, ашиглалтын зөвшөөрөл бүхий талбайн дотор байрласан. Энд 10тн-ын багтаамжтай төмөр торхтой тосолгооны материал, тос болон уурхайн хамгийн багадаа 30 хоногийн ажлыг хангах хэрэгцээний түлшний багтаамж бүхий ёмкость байрлана.

БҮЛЭГ.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

Байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт	
Физик газарзүй	<p>Сайнцагаан, Өлзийт сумдын нутаг нь Монгол орны говь-хээрийн шилжилтийн бүсэд хамаарах бөгөөд талархаг, долгиорхог гадарга, нам уулс, толгод, хуурай сайр, хотгор хонхор, элсэрхэг болон хайргархаг гадарга ээлжлэн тархсан байгалийн тогтоцтой. Энэ бүс нутаг нь эх газрын хуурай уур амьсгалын нөлөөнд дор хөгжсөн тул газрын гадаргын элэгдэл, салхины зөөгдөл, хөрсний хуурайшилт, ургамлын бүрхэвчийн сийрэгжилт зэрэг байгалийн эмзэг шинжүүд тод илэрдэг.</p> <p>Сайнцагаан сумын хувьд аймгийн төвийн суурьшлын бүс орших тул байгалийн гадарга нь төв суурин, зам, барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, хөдөө аж ахуйн ашиглалт зэрэг хүний үйл ажиллагааны нөлөөлөлд илүү өртсөн байна. Харин сумын төвөөс алслагдсан хэсгүүдэд говь-хээрийн бэлчээрийн хэв шинж давамгайлж, хуурай хээрийн ургамалжилт, сайр жалга, бага өндөрлөгүүд тархсан байна.</p> <p>Өлзийт сум нь байгалийн өвөрмөц тогтоц, аялал жуулчлалын нөөцөөрөө онцлог. Тус сумын нутагт Цагаан суварга, Өөш манхан, Хэвтээ-Босоогийн агуй, Алаг зандангийн агуй, Морин толгойн цав, Монтойн хайлааст ам зэрэг байгалийн үзэсгэлэнт, геоморфологийн өвөрмөц тогтоцууд оршдог.</p>
Уур амьсгалын нөхцөл	<p>Судалгааны бүс нь эх газрын эрс тэс, хуурай уур амьсгалтай. Жилийн болон хоногийн температурын хэлбэлзэл их, хур тунадасны хэмжээ бага, ууршилт өндөр, салхи шуурганы давтамж ихтэй нь тухайн бүс нутгийн байгаль орчны үндсэн онцлог юм. Дундговь аймаг нь Монгол орны төв хэсгийн талархаг, говь-хээрийн бүсэд орших тул хуурайшилт, салхины идэвхжил, хөрсний чийгийн дутагдал байгаль орчны төлөвт шууд нөлөөлдөг.</p> <p>Өвлийн улиралд хүйтэн, хуурай, цас багатай, зарим жилд зудын эрсдэл үүсэх нөхцөлтэй. Хаврын улиралд салхины хурд нэмэгдэж, шороон шуурга, тоосжилт ихсэх хандлагатай. Зуны улиралд хур тунадас богино хугацаанд аадар хэлбэрээр орох нь элбэг бөгөөд гадаргын урсац түр хугацаанд нэмэгдэх боловч тогтмол урсац бүхий гол горхи ховор байдаг. Намрын улиралд агаарын температур огцом буурч, хөрсний чийгийн алдагдал үргэлжилдэг.</p> <p>Өлзийт сумын байгаль орчны үнэлгээний материалуудад тухайн бүсийг хуурай, эх газрын уур амьсгалтай, байнгын хүчтэй салхи, шороон шуурга нь ургамал, амьтны аймагт ихээхэн нөлөөлдөг гэж тодорхойлсон байна. Ийм нөхцөл нь хөрсний өнгөн үеийн элэгдэл, бэлчээрийн доройтол, ургамлын нөхөн сэргэх чадвар буурах, тоосжилт нэмэгдэх эрсдэлийг бий болгодог.</p>
Ус	<p>Сайнцагаан, Өлзийт сумдын нутагт байнгын урсац бүхий гадаргын ус ховор бөгөөд усан хангамжийн үндсэн эх үүсвэр нь газрын доорх ус, булаг шанд, худгийн ус байна. Говь-хээрийн бүсийн хуурай уур амьсгал, хур тунадасны хомсдол, ууршилтын өндөр хэмжээ зэргээс шалтгаалан гадаргын усны хуримтлал тогтвортой бус, ихэнх нуур тойром нь улирлын шинжтэй байдаг.</p> <p>Сайнцагаан сумын нутагт Бага булаг, Зүлэгтий, Хүйтэн булаг, Хоолойн гашуу, Хув, Наран, Даргиат, Тагт, Бунхат зэрэг 20 шахам рашаан, булаг шанд байдаг гэж сумын танилцуулгад дурдсан байна. Мөн хур бороо элбэг жилүүдэд Мандалын нуур, Улаан нуур, Равжихын нуур, Шорвогт тойром зэрэг нуур, тойрмууд усждаг байна.</p> <p>Өлзийт сумын хувьд говийн хуурай бүсэд орших хэдий ч зарим хөндий, сайр дагуу цэнгэг уст булаг, шанд тохиолддог. Тухайлбал Их нартын хөндий орчимд цэнгэг, хүйтэн уст булаг шанд байдаг гэж байгаль орчны үнэлгээний материалд дурдсан байна. Гэсэн хэдий ч эдгээр булаг шандын ундарга улирлын хэлбэлзэлтэй, хур тунадас, газрын доорх усны нөхөн сэргээлтээс ихээхэн хамааралтай тул хамгаалалтын бүс тогтоох, малын усалгааны ачааллыг зохицуулах, бохирдлоос хамгаалах шаардлагатай.</p>
Ургамал, амьтан	<p>Сайнцагаан, Өлзийт сумдын ургамал нөмрөг нь говь-хээр, цөлөрхөг хээрийн хэв шинжтэй. Ургамлын бүрхэвчийн нягтрал бага, хур тунадас, хөрсний чийг, бэлчээрийн ашиглалт, салхи шуурганы нөлөөнөөс хамааран жил бүр өөрчлөгдөх хэлбэлзэлтэй. Зонхилох ургамалд хялгана, таана, хүмүүл, шарилж,</p>

	<p>баглуур, бударгана, харгана, боролзой, заг, хайлаас, сөөглөг болон олон наст өвслөг ургамлууд орно.</p> <p>Сайнцагаан сумын ус чийг арай илүүтэй булаг шанд, нуур тойром орчмын хэсэгт нугархаг, давссаг, чийгсүү ургамлын бүлгэмдэл хэсэгчлэн тохиолдох боломжтой. Харин суурин газрын ойролцоо талхлагдал, замын тоосжилт, малын бэлчээрлэлт, гэр хорооллын нөлөөгөөр ургамлын бүрхэвч тасалдах, хог ургамал нэмэгдэх шинж илэрч болно.</p> <p>Өлзийт сумын хувьд цөлийн болон цөлөрхөг хээрийн ургамалжилт давамгайлна. Хуурай сайр, толгод, чулуурхаг бэл, элсэрхэг гадарга бүхий хэсгүүдэд ургамлын бүрхэвч маш сийрэг, нөхөн сэргэх чадвар удаан байдаг. Иймээс аливаа барилга байгууламж, зам, карьер, түр кемп, аялал жуулчлалын байгууламж байгуулах тохиолдолд ургамлын бүрхэвчийг аль болох бага хөндөх, талбайг хязгаарлах, нөхөн сэргээлтийн арга хэмжээг урьдчилан төлөвлөх шаардлагатай.</p>
<p>Хөрсөн бүрхэвч</p>	<p>Судалгааны бүсийн хөрсөн бүрхэвч нь говь-хээрийн хуурай нөхцөлд үүссэн нимгэн, карбонатлаг, чулуурхаг, элсэнцэр болон хайргархаг бүтэцтэй хөрсөөр төлөөлөгдөнө. Ургамлын бүрхэвч сийрэг, органик бодисын агууламж харьцангуй бага, хөрсний чийгийн нөөц хязгаарлагдмал байдаг тул гадаргын эвдрэл, салхины элэгдэл, тоосжилтод өртөмтгий.</p> <p>Сайнцагаан сумын төв суурин бүс орчимд хөрсөн бүрхэвч нь барилгажилт, авто зам, гэр хороолол, хог хаягдал, тээврийн хөдөлгөөн, малын нягтрал зэрэг хүний үйл ажиллагааны нөлөөлөлд тодорхой хэмжээгээр өртсөн байна. Харин сумын хөдөө хэсэгт бэлчээрийн ашиглалт голлох нөлөөллийн хүчин зүйл болж, малын төвлөрөл ихтэй худгийн орчим, өвөлжөө, хаваржаа, зам дагуу хөрсний нягтаршил, ургамлын бүрхэвчийн сийрэгжилт ажиглагдах боломжтой.</p> <p>Өлзийт сумын нутагт элсэрхэг, хайргархаг, чулуурхаг гадарга, нам уулс, цав толгод, манхан, хуурай сайр бүхий ландшафт зонхилох тул хөрсний элэгдэл, эвдрэл, салхины зөөгдөлд мэдрэмтгий. Ялангуяа Цагаан суварга, Өөш манхан зэрэг аялал жуулчлалын бүс, замгүй хөдөлгөөн ихтэй хэсэгт хөрсний өнгөн үе эвдрэх, ургамлын бүрхэвч талхлагдах, байгалийн тогтоцын хэв шинж алдагдах эрсдэл өндөр байна.</p>

БҮЛЭГ.3.ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Энэ бүлэгт төслөөс байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг нөлөөлөлд өртөх орчноор буюу газрын гадарга, уур амьсгал, агаарын чанар, гадаргын болон гүний ус, хөрсөн бүрхэвч, ургамлын аймаг, амьтны аймаг, түүх соёлын дурсгал, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэнд зэрэг чиглэлүүдээр авч үзэн тодорхойлж, тэдгээр нөлөөллийн эрчим, цар хүрээг үнэлэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тусгасан болно.

3.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг Байгаль Орчин Ногоон Хөгжлийн Сайдын 2014 оны 04 сарын 10-ны өдрийн А/117 дугаар тушаалын 2 дүгээр хавсралт, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх шинэчилсэн аргачлал болон түүнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2017 оны 12 сарын 31-ны өдрийн А/331 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу хийж гүйцэтгэлээ.

Төслийн үйл ажиллагаанаас үүдэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах ажлыг зохион байгуулахын тулд нөлөөллийн хэмжээг тодорхойлно. Нөлөөллийн хэмжээг тодорхойлох нь тухайн хүний ойлголтоос ихээхэн хамаардаг тул ихэнх тохиолдолд байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрээр дараах шаардлагыг мөрдөх шаардлагатай. Нөлөөллийн хэмжээг 3 хүчин зүйлээр тодорхойлно. Нөлөөлөл тус бүрд дээр дурдсан хүчин зүйл бүр 1, 2, 3 гэсэн үнэлгээ өгөх бөгөөд энэ нь тухайн нөлөөллийн хэмжээ, тархалт, давтамжийг харуулна. Үүнд: Нөлөөллийн хэмжээ, хугацаа, нөлөөлөлд өртөх газар нутаг, нөлөөлөл тохиолдох, давтагдах магадлал.

Хүснэгт 15. Нөлөөллийг тооцох аргачлал

Хэмжээ тархалт (M) 1, 2 ба 3	Нөлөөллийн хэмжээг тодорхойлно. (бага, дунд, их) Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хугацааг тодорхойлно. (богино, дунд, урт хугацаа)
Хамрах хүрээ (S) 1, 2 ба 3	Төслийн үйл ажиллагаанаас нөлөөлөлд өртөх газар зүйн байрлал, талбай (тухайн талбай орчимд, арай өргөвтөр талбайд, нэлээд өргөн газар нутгийг хамарсан)
Давтамж/магадлал (F) 1, 2 ба 3	Дахин давтагдах магадлал ба дахин давтагдах тоо (бага магадлалтай, өндөр магадлалтай, тохиолдол нь тодорхой)

Болзошгүй нөлөөллийг хэмжээ, хамрах хүрээ, давтамж гурвын үржвэрээр тооцно.

$$M \times S \times F = \text{Болзошгүй нөлөөллийн хэмжээ}$$

Нөлөөллийн хамгийн бага хэмжээ 1 (1x1x1), хамгийн их хэмжээ нь 27 (3x3x3) байна. Нөлөөллийн хэмжээ 6-аас доош байгаа тохиолдолд үл мэдэгдэх нөлөөлөл гэж үзнэ. Дараах хүснэгтэд хэмжээ, хамрах хүрээ, давтамж гуравт үнэлгээг харгалзуулах журам, нэгдсэн үнэлгээг тооцоолох тухай журмыг харуулсан болно. Хэрвээ тухайн нөлөөлөл хуулийн зохицуулалт хийх шаардлагатай болохоор бол мэдэгдэхүйц нөлөөлөлд тооцогдоно.

Хүснэгт 16. Байгаль орчинд нөлөөлөх байдлыг тодорхойлох шалгуур

Төрөл/үнэлгээ Шалгуур	Төрөл/үнэлгээ Шалгуур		
М: Хэмжээ, тархалт			
Түвшин -1	Түвшин -1 Бага болон богино хугацааны нөлөөлөл - энэ хоёр нөхцөлийг зэрэг хангасан тохиолдолд		
Түвшин -2	Дунд зэрэг, эсвэл дунд хугацааны нөлөөлөл - Энэ хоёр нөхцөлийн аль нэгийг хангасан тохиолдолд		
Түвшин -3	Томоохон, эсвэл урт хугацааны нөлөөлөл- Энэ хоёр нөхцөлийг аль нэгийг хангасан тохиолдолд		
Нөлөөллийн түвшин			
Бага зэргийн нөлөөлөл	Хэмжээ, тархалтын хувьд бага	Богино хугацааны	Төсөл дууссанаас хойш 6 сарын хугацаа нөхөн сэргээгдэх боломжтой
Дунд зэргийн нөлөөлөл	Хэмжээ, тархалтын хувьд дунд зэрэг	Дунд хугацааны	Төсөл дууссанаас хойш 6 сараас 2 жилийн хугацаанд нөхөн сэргээгдэх боломжтой.
Томоохон нөлөөлөл	Хэмжээ, тархалтын хувьд их	Урт хугацааны	Төсөл дууссанаас хойш 2 ба түүнээс жилийн хугацаанд дараа нөхөн сэргээгдэх боломжтой
S: хамрах хүрээ буюу газарзүйн тархалт			
Үнэлгээ= 1	Нөлөөлөх талбай: зөвхөн төслийн талбайн хүрээнд		
Үнэлгээ =2	Нөлөөлөх талбай: төслийн талбайгаас гадагш 500м-ийн радиуст		
Үнэлгээ =3	Нөлөөлөх талбайн: 500м-ийн радиусаас цааш талбайг хамарсан		
F: Давтамж буюу магадлал			
Үнэлгээ= 1	Бага магадлалтай- Санал болгож буй төсөлтэй ижил төслүүдийн хувьд үүсэж байсан, энэ төслийн хувьд бараг тохиолдох боломжгүй		
Үнэлгээ =2	Дунд зэргийн магадлалтай - Энэ төслийн хувьд тохиолдох боломжтой		
Үнэлгээ =3	Өндөр магадлалтай - Энэ төслийн хувьд бараг л тохиолдоно		
Нийт түвшин= $M \times S \times F$	Үнэлгээ	Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хэмжээ	
Нөлөөллийн түвшин бага	<6	Бага - Тийм ч анхаарал татахуйц биш	
Нөлөөллийн түвшин дунд	6-18	Дунд - урьдчилан сэргийлж, нөлөөллийг бууруулж зохицуулах боломжтой	
Нөлөөллийн түвшин өндөр	>18	Их буюу өндөр - урьдчилан сэргийлж, нөлөөллийг бууруулж зохицуулах боломжтой	
Бууруулж болохуйц нөлөөлөл: Нөлөөлөл нь их боловч тодорхой аргыг хэрэглэснээр нөлөөллийн түвшнийг бууруулах боломжтой.			
Үр дүнтэй (зэрэг нөлөөлөл): Нөлөөлөл нь их боловч байгаль орчин, хүний хэрэглээ, хүний үнэ цэнийг сайжруулж чадна			

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийг газрын гадарга, уур амьсгал, агаарын чанар, дуу чимээ, усан орчин, хөрс, ургамал үзүүлэх байдлаар нь үнэлж, үр дүнг тодорхойлов.

Хүснэгт 17. Агаарын чанарт нөлөөлөх байдлын үнэлгээний матриц

№	Нөлөөлөл үүсгэх үйл ажиллагаа	Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн шалгуур үзүүлэлт			Болзошгүй нөлөөллийн зэрэглэл
			Үзүүлэлт	Цар хүрээ	Магадлал	
1.	Уурхайн ажилчдын тосгон, агуулах зэрэг байгууламжуудыг барих	Уурхайн хотхон, шатах тослох материалын (ШТМ) агуулах нь уурхайн нийт талбайн 4.7 га талбайд байгуулагдана. Ингэхдээ хөрс хуулалт, хашаа, далан, суваг шуудууг байгуулахад тоос үүснэ.	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбай Хугацаа: Богино хугацааны Эрчим: Бага	Бага	Боломжтой	Бага
2.	Хөрс сийрэгжүүлэх өрөмдлөг тэсэлгээний ажил хийх	Ил уурхайн тэсэлгээний ажлыг 7 хоногт 1 удаа хийж, олборлолтын ажил жилд 10 сарын хугацаатай явагдана. Тоосжилт олборлолтын эх үүсвэрээс дунджаар 3 км зайд тархана.	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбай Хугацаа: Урт хугацааны Эрчим: Бага	Их	Боломжтой	Их
3.	Хөрс хуулах	Нийт 4 жилийн хугацаанд 72.87 мян.м ³ хөрс хуулж жонш олборлох үед тоос шороо агаарт тархана	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Орон нутгийн Хугацаа: Урт хугацааны Эрчим: Бага	Их	Боломжтой	Их
4.	Жонш олборлох	Ил уурхайн олборлолтын ажлын үед хүнд машин механизмын хөдөлгөөнөөс дуучимээ ихсэх	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбайн Хугацаа: Урт хугацааны Эрчим: Бага	Дунд	Болзошгүй	Дунд
5.	Хөрсний овоолго байгуулах	Нийт ажиллах 4 жилийн хугацаанд 1.7 га хөрсний овоолго байгуулна. Уурхайн овоолгын үйл ажиллагаанаас ялгарах нийт тоосны жилийн дундаж агууламжийн хэмжээ овоолго орчим 50190 мкг/м ³ , PM10 тоосонцрын	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбайн Хугацаа: Түр хугацааны Эрчим: Бага	Дунд	Боломжтой	Дунд

		хэмжээ 10-30 мкг/м ³ агууламжтай байна.Тооцооллыг дээр үзүүлсэн.				
6.	Хөрс хуулах, тээвэрлэх, ачих, буулгах, овоолгод байршуулах	Ашиглалтын жилүүдэд ил уурхайгаас хөрсний овоолго хүртэлх зай 1.3-1.5 км байх бол жоншны уурхайн гадна байрлах түр хадгалах задгай агуулах хүртэл тээвэрлэх зай дунджаар 0.9-1.0 км орчим байна. Үүнээс тоосжилт үүсэж агаарын чанарт нөлөөлнө.	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбай Хугацаа: Урт хугацааны Эрчим: Бага	Дунд	Боломжтой	Дунд
7.	Ил уурхайн хүнд машин механизмын хөдөлгөөн	Уулын ажлын гүйцэтгэлд экскаватор, автосамосвал, бульдозер зэрэг хүнд даацын машинуудыг ашиглах ба тэдгээрээс утаа болон дуу чимээ үүсэж орчныг бохирдуулах	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбайн Хугацаа: Урт хугацааны Эрчим: Бага	Дунд	Болзошгүй	Дунд
8.	Аливаа тээврийн үйл ажиллагаа	Машин техник, тоног төхөөрөмжийн хөдөлгүүрийн яндангаас гарах утаа, тортог зэрэг нь агаарын чанарт нөлөөлөх	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбайн Хугацаа: Урт хугацааны Эрчим: Бага	Бага	Болзошгүй	Бага
9.	Дизель генератор ажиллуулах	Уурхайн захиргааны болон кемпийн барилга байгууламжуудын цахилгааныг 100 кВт-ын 2 ширхэг дизель генератораар хангахаар төлөвлөөд байна. Эдгээр дизель генераторуудаас хорт хий ялгарч агаарын чанарт нөлөөлнө.	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбайн Хугацаа: Урт хугацааны Эрчим: Бага	Дунд	Болзошгүй	Дунд

Хүснэгт 3.1. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвчид нөлөөлөх байдлын үнэлгээний матриц

№	Нөлөөлөл үүсгэх үйл ажиллагаа	Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн шалгуур үзүүлэлт			Болзошгүй нөлөөллийн зэрэглэл
			Үзүүлэлт	Цар хүрээ	Магадлал	

1.	Тоосжилт бууруулах үйл ажиллагаа Орчны тоосжилт бууруулахад ус ашиглах	18.2 мян.м2 талбай бүхий замыг услахад жил тутамд гүний ус 728 м 3 хэмжээгээр ашиглана.	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбай Хугацаа: Богино хугацааны Эрчим: Дунд	Дунд	Боломжгүй	Дунд
2.	Жонш олборлолтын үед ухалт хийх	Уурхайн олборлолтын үед усны урсцын горимд өөрчлөгдөж болзошгүй	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбай Хугацаа: Урт хугацааны Эрчим: Дунд	Их	Боломжгүй	Дунд
3.	Унд ахуйн усны хэрэглээ Уурхайн ажилчдын хэрэглээний усыг хангах	Уурхайд нийт 161 хүн ажиллах ба жилд нийт 1127 м 3 ус хэрэглэнэ.	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Орон нутгийн Хугацаа: Урт хугацааны Эрчим: Дунд	Их	Боломжгүй	Дунд
4.	Ахуйн хог хаягдал Уурхайн тосгоноос гарах ахуйн хатуу болон шингэн хог хаягдах	Уурхайн тосгоноос гарах ахуйн хатуу, шингэн хог хаягдлыг зүй зохистой зайлуулаагүй тохиолдолд жижиг булаг болон гадаргын усыг бохирдуулах.	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбайн Хугацаа: Урт хугацааны Эрчим: Бага	Дунд	Магадгүй	Бага

Хүснэгт 18. Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээний матриц

№	Нөлөөлөл үүсгэх үйл ажиллагаа	Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн шалгуур үзүүлэлт			Болзошгүй нөлөөллийн зэрэглэл
			Үзүүлэлт	Цар хүрээ	Магадлал	
1.	Уурхайн дэд бүтцийн байгууламжуудыг барих, талбайг бэлтгэх	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн болон байнгын газар шорооны ажилтай холбоотойгоор үүсэх тоосжилт ургамлан нөмрөгт дам нөлөөлөл үзүүлэх байгуулагдана. Ингэхдээ хөрс хуулалт, хашаа, далан, суваг шуудууг байгуулахад тоос үүснэ.	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбай Хугацаа: Богино хугацааны Эрчим: Бага	Бага	Боломжтой	Бага
2.	Ил уурхайн олборлолтын үед өрөмдлөг,	Олборлолтоос тоос үүсэж ойр орчмын 3 км	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг	Бага	Боломжтой	Бага

	тэсэлгээг гүйцэтгэх	талбайн ургамлан нөмрөг тоосонд дарагдана. Үр дүнд нь фотосинтезийн үйл ажиллагаа, ургамлан нөмрөгийн бүтээмж буурах	Газарзүйн цар хүрээ: Төслийн талбай Хугацаа: Урт хугацааны Эрчим: Бага			
3.	Хөрс болон жонш ачих, буулгах	Ачилт буулгалтын үед үүссэн тоос ургамлан нөмрөгийн гадаргуу дээр тогтож ургамлын бүтээмжийг бууруулах	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Орон нутгийн Хугацаа: Урт хугацааны Эрчим: Дунд	Дунд	Боломжтой	Дунд
4.	Хүнд машин механизмын хөдөлгөөн	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс гарах тоос, утаа, олон төрлийн хүнд элементүүд тухайн орчныхоо 15-50 м зай доторх ургамлан нөмрөгийн идэвхтэй фотосинтезийн үйл ажиллагааг бууруулах.	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбайн Хугацаа: Урт хугацааны Эрчим: Дунд	Дунд	Боломжтой	Дунд
5.	Уурхайн карьер үүсгэх талбайн хөрсийг хуулж шимт хөрсний овоолго үүсгэх	Шимт хөрс, хоосон чулуулгийн овоолго байгуулах талбайн ургамлан нөмрөг дарагдаж, үндсэн хэв шинж, шинж чанараа алдах	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбайн Хугацаа: Түр хугацааны Эрчим: Бага	Бага	Болзошгүй	Бага
6.	Засвар үйлчилгээ	Тээврийн машин техникийн засвар үйлчилгээний ажлын үед тос тосолгооны материал асгарах Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралт үүсэж хөрсийг бохирдуулснаар ургамлан нөмрөгийг хордуулах	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбай Хугацаа: Урт хугацааны Эрчим: Бага	Бага	Болзошгүй	Бага

Хүснэгт 19. Амьтны аймагт нөлөөлөх байдлын үнэлгээний матриц

№	Нөлөөлөл үүсгэх үйл ажиллагаа	Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн шалгуур үзүүлэлт			Болзошгүй нөлөөллийн зэрэглэл
			Үзүүлэлт	Цар хүрээ	Магадлал	
1.	Барилга байгууламж барих	Уурхайн дэд бүтцийн байгууламжуудыг барих талбайг бэлтгэж хөрс хуулах үед амьтдын амьдрах орчин доройтох, сүйдэх, амьтад дайжих	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбай Хугацаа: Богино хугацааны Эрчим: Дунд	Бага	Боломжтой	Бага
2.	Ил уурхайн олборлолтын үед ерөмдлөг, тэсэлгээг гүйцэтгэх	Чимээ, чичирхийллээс амьтад үргэн дайжих, дуу чимээний стресс үүсэх	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбай Хугацаа: Урт хугацааны Эрчим: Дунд	Бага	Боломжтой	Бага
3.	Уурхайн карьер үүсгэх, хөрс хуулах, хүдэр олборлох үйл ажиллагаа явуулах	Уурхайн карьерт амьтан орж унаж бэртэх	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Орон нутгийн Хугацаа: Урт хугацааны Эрчим: Бага	Дунд	Боломжтой	Дунд
4.		Хөрсөнд үүрлэн амьдрагч жижиг хөхтөн амьтад, бусад шавж зэрэг амьд биетүүдийн амьдрах орчин алдагдах, уурхайн үйл ажиллагаанд өртөх, устах	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбайн Хугацаа: Урт хугацааны Эрчим: Дунд	Дунд	Боломжтой	Дунд
5.	Хүнд машин механизмын хөдөлгөөн	Хөрс болон жонш тээвэрлэх үед талбай орчмын зарим жижиг хөхтөн амьтад машин механизмд дайруулах	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбайн Хугацаа: Түр хугацааны Эрчим: Маш бага	Бага	Болзошгүй	Бага
6.	Уурхайн карьер үүсгэх талбайн хөрсийг хуулж хөрсний овоолго үүсгэх	Амьдрах орчны хэв шинж алдагдах	Нөлөөллийн хэлбэр: Шууд сөрөг Газарзүйн цар хүрээ: Төслийн талбай Хугацаа: Урт хугацааны Эрчим: Дунд	Дунд	Болзошгүй	Дунд

БҮЛЭГ.4.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАНИЛЦУУЛГА

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНДЭСЛЭЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлагдах төсөл хэрэгжүүлэх, дараа дараагийн жилүүдэд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл бүхий эрхзүйн баримт бичиг юм.

2019 оны А/618 дугаар тушаалаар “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3.4-т “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.8-д заасны дагуу төсөлд ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүлээн авч, түүнд хийсэн ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн биелэлтийг хянаж, дараагийн жилд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянаж батална” гэж заасны дагуу тус 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 58 дугаар тогтоолоор баталсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, БОНХС-ын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 тоот сайдын тушаал, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу тус тус үндэслэн боловсруулав.

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“ИДЭР МАКС” ХХК нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилго нь хайгуулын үйл ажиллагааг Монгол улсын хууль, журам, дүрэм болон компаниас баримталж буй байгаль орчны менежментийн үндсэн бодлогын дагуу явуулахад оршино. Манай компани хайгуулын үйл ажиллагаа явагдаж буй тухайн орчинд байгаль орчны зохистой менежментийг бий болгохын тулд байгаль хамгаалах арга хэмжээг жил бүр төлөвлөн түүнийг хэрэгжүүлэх болно.

Тус компани байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний дагуу жил бүрийн хайгуулын ажил эхлэхээс өмнө байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө болон хайгуулын аливаа үйл ажиллагаатай холбоотой нэмэлт ажлууд хийх бүрд нь байгаль орчныг хамгаалах нэмэлт менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулахын зэрэгцээ Баян-Овоо, Номгон сумын байгаль орчны улсын байцаагчтай хамтран үзлэг шалгалтыг тухай бүрд нь хийж гүйцэтгэж байхаар төлөвлөж байна. “ИДЭР МАКС” ХХК нь байгаль орчныг хамгаалах талаарх бодлогыг дараах байдлаар тодорхойлсон:

- Бохирдлоос сэргийлэх зорилгоор байгаль орчинд учрах нөлөөллийг тодорхойлж, үнэлж, бууруулж, зохицуулах арга хэмжээ авна.
- Байгаль орчны талаарх хууль тогтоомж болон бусад бүх шаардлагад нийцүүлэх.
- Хайгуулын ажлын явцад хийгдэх өөрийн бүх үйл ажиллагааны явцад байгаль орчинд тавих анхаарлаа орхигдуулахгүй.
- Компанийн ажилтнууд, нутгийн иргэдтэй байгаль орчны асуудлаар нээлттэй, шударга, ажил хэрэгч харилцаа хөгжүүлнэ.

- Нутгийн ард иргэдийн уламжлагдаж ирсэн эрх, соёлын өвийг хүндэтгэж хамгаална.

“ИДЭР МАКС” ХХК -ийн Дундговь аймгийн Өлзийт, Сайнцагаан сумдын нутаг дэвсгэрт хэрэгжих “Уушиг-Уул 1” хайлуур жоншны ордын ил, далд аргаар ашиглах төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын шаардлагад нийцүүлж боловсруулав. Идэр макс ХХК нь 2026 оны 2-р улирлаас менежментийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа эхлүүлж хэрэгжүүлнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь:

- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
- Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Хүснэгт 20. Байгаль орчны төлөвлөгөөний зардал задаргаа

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, мян.төг
1.	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардал	102 500.0
2.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	900.0
Байгаль орчны менежмент төлөвлөгөөний нийт зардал		103 400.0

4.1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОХТ/ нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “ИДЭР МАКС” ХХК-аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

Хүснэгт 21. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний нийт зардал

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, мян.төг
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1 500.0
2.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	72 000.0
3.	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	16 000.0
4.	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	11 200.0
5.	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	2 700.0
6.	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нийт зардал мян.төг		103 400.0

4.1.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Цаашид хэрэгжүүлэх менежментийн төлөвлөгөө: Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны үндсэн бүрдэл хэсгүүд (агаар, ус, хөрс, газрын гадарга, амьтан гэх мэт)–ээр тооцож гаргасан төслийн үйл ажиллагааны хугацаанд биелүүлэх дараах арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөг төрийн захиргааны төв байгууллагаар баталгаажуулан, хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн төлөвлөгөөнд байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, сэргийлэх арга хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан болно.

Хүснэгт 22. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний нийт зардал

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нэгж үнэ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Хууль эрх зүйн шаардлага
0	1.	2.	3.	4.	5.	6.	7.
Агаар орчин							
1.	Хөрс хуулалт, барилга байгууламж барих, жонш олборлох, овоолго үүсгэх зэргээр тоосжилт үүсэж төсөл хэрэгжих орчны агаарын чанарт сөргөөр нөлөөлнө.	Уурхайн авто замуудыг болон жонш олборлолтын талбайн тоосжилтыг бууруулахын тулд усалгаа хийх (Дулааны улиралд усалгааг тогтмол хийх)	Уурхайн зам, жонш олборлолтын талбай	Үйл ажиллагааны зардалд тусгах		6-11 сар	MNS ISO 4227:2002 , “Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө”, MNS 4585-2025 , “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага”, MNS 5885:2008 , “Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага”, MNS 6063:2010 , “Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны
2.	Тээврийн хэрэгсэл, хүнд даацын машин механизмын хөдөлгөөний нөлөөгөөр тоосжилт үүсэж агаарын чанарт сөргөөр нөлөөлөх	Хурдны хязгаар тогтоож 30 км/цагаас хэтрэхгүй байх хурдны хязгаарлалтыг заасан тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах	Уурхайн дотоод замын шаардлагатай хэсгүүдэд	Үйл ажиллагааны зардалд тусгах		6-11 сар	
3.		Уурхайн талбай дахь замын сүлжээг сайжруулсан шороон зам болгох, шороон замыг дагтаршуулах	Уурхайн дотоод зам	Үйл ажиллагааны зардалд тусгах		6-11 сар	
4.	Хүнд машин механизм засварын газар, машины зогсоол дахь машин, техникүүд агаар орчныг бохирдуулж болзошгүй	Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизмаас ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах	Уурхайд ашиглагдаж буй нийт тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм	1 500.0		6-11 сар	
5.		Уурхайн үйл ажиллагаа болон барилгын ажилд ашиглагдаж байгаа бүх тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм, техникийг тогтмол үзлэгт хамруулах, засвар үйлчилгээг тогтмол хийх					

						агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ”,	
Усны нөөц, чанар							
6.	Уурхайн үйл ажиллагааны улмаас газрын доорх усны түвшин буурах	Ил уурхайд шүүрч буй усыг тогтмол шавхаж зам талбайн тоосжилтыг багасгах зорилгоор ашиглах	Үйл ажиллагааны хүрээнд	Үйл ажиллагааны зардалд тусгах	6-11 сар	“Унд, ахуйн зориулалттай усны төвлөрсөн хангамжийн эх булгийг сонгох журам, эрүүл ахуйн шаардлага” MNS 0900-2018 , “Ундны усны чанарын стандарт” Ус ашигласны төлбөр (Засгийн газрын 2005 оны 7-р тогтоол) MNS 4943-2018 , “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус”	
7.		Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлтэд зааснаас бусад зориулалтаар ус ашиглах, төлбөр хураамжийг хугацаанд нь төлөхгүй байх зэрэг Усны тухай хууль тогтоомж зөрчсөн үйлдэл гаргахгүй байх	Үйл ажиллагааны хүрээнд	Үйл ажиллагааны зардалд тусгах	6-11 сар		
8.		Ус ашиглах гэрээ байгуулж, ус ашиглалтын төлбөрийг гэрээний дагуу тооцож, тогтоосон хугацаанд нь төлөх	Үйл ажиллагааны хүрээнд	Үйл ажиллагааны зардалд тусгах	6-11 сар		
9.		Усны бүх эх үүсвэрүүдийг тоолууржуулах		Нийт ажилчдыг хамруулах	Үйл ажиллагааны зардалд тусгах		6-11 сар
10.							
11.							
Хөрсөн бүрхэвч болон газрын гадарга							
12.	Ил уурхай, овоолго болон бусад холбогдох байгууламжийн үйл ажиллагааны улмаас газрын хэлбэр, төрхөд өөрчлөлт орох, газрын хэвлий эвдрэх	Аливаа газар хөндөх үйл ажиллагааны үед үржил шимт хөрсийг урьдчилан 0.2-0.35 м-ийн зузаантайгаар хуулж тусгайлан хадгалах	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгагдсан	6-11 сар	MNS 3985:1987 Байгаль хамгаалал. Хөрс. Ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр төрөл. MNS 5850:2019 Хөрсний чанар.	
		Шимт, шимэрхэг хөрсний овоолгуудын байршил, хэмжээг бүртгэх, газарзүйн мэдээллийн системд зурагжуулах	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	Үйл ажиллагааны зардалд тусгах	6-11 сар		

13.		Шимт болон шимт хөрсийг алдагдахаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулах, хадгалах талбайг зөв сонгох, овоолгыг зөв үүсгэхэд хяналт тавих (3 метрээс өндөргүй овоолох)	Уурхайн байршилд	Үйл ажиллагааны зардалд тусгах	6-11 сар	Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ.
		Хадгалсан шимт, шимэрхэг хөрсийг нөхөн сэргээлт, ногоон байгууламжид эргүүлэн ашиглах	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгагдсан	6-11 сар	
14.	Уул уурхайн үйл ажиллагааны явцад хүнд даацын техник тоног төхөөрөмжийн хөдөлгөөнөөр хөрсний элэгдэл, эвдрэл нэмэгдэх, доройтох, талхлагдах,	Уурхайн талбай дахь замын сүлжээг сайжруулсан шороон зам болгох, шороон замыг дагтаршуулах	Уурхайн дотоод төв замууд	Агаарын чанарын хэсэгт тусгагдсан	6-11 сар	
15.		Ашиглалтын явцад зөвхөн технологийн процессуудад зайлшгүй шаардлагатай замуудыг байгуулан, маршрутыг тогтоож, онц шаардлагагүй олон салаа зам гарч газрын гадарга эвдэгдэхээс сэргийлэх	Уурхайн дотоод төв замууд	Үйл ажиллагааны зардалд тусгах	6-11 сар	
Ургамлан бүрхэвч, зэрлэг ан амьтан болон мал сүрэгт						
16.	Уурхайн үйл ажиллагаанаас 1.7 га талбай шууд эвдрэлд орох ба үржил шимт хөрс хуулах ажил хийгдэх тул ургамлан нөмрөг шууд устах	Уурхай ашиглалтын дараагаар биологийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж гүйцэтгэх	Тухайн байршилд	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгагдсан	6-11 сар	MNS 5918:2008 , “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага” MNS 5918:2008 , Эвдэрсэн газрын нөхөн сэргээх MNS 5914:2008 Уул уурхайн үйлдвэрлэлд өртөн эвдэрсэн газрыг нөхөн сэргээх MNS 5914:2008 стандарт
17.	Уурхайн машин техникээс гарах тоос, утаа, олон төрлийн хүнд элементүүд тухайн орчныхоо 15-50м зай доторх ургамлан нөмрөгийн фотосинтезийн идэвхтэй туяа шингээлтийг бууруулах	Уурхайн авто замуудыг дулааны улиралд болон тоос ихээр босох үеүдэд усалгаа хийж, чийгшүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Төслийн талбай дахь замуудад	Агаарын чанарын хэсэгт тусгагдсан	6-11 сар	
18.	Ургамлын төрөл зүйл хомсдох	Төслийн талбай дахь ургамлан бүрхэвч, ховор ургамлын суурь судалгаа, хяналт мониторинг хийх	Төслийн талбай болон төслийн талбайгаас гадагш 5 км газарт	Орчны хяналт шинжилгээний зардалд тусгагдсан	6-11 сар	
Амьтны аймаг						

		Зэрлэг ан амьтдын судалгаа хийж, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах талаар дүгнэлт гаргах	Төслийн талбайн ойр орчимд	Орчны хяналт шинжилгээний зардалд тусгагдсан	6-11 сар	2019 оны 12 сарын 11 өдөр УУХҮС, НХС-ын хамтарсан А/231 А/368 дугаарт тушаалаар батлагдсан “Ил уурхайн аюулгүй байдлын дүрэм” болон “Хог хаягдлын тухай хууль”, “Байгаль орчны тухай хууль”
19.	Дуу чимээ, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, гэрлийн нөлөөгөөр байршиж буй газар нутгаасаа үргэх, дайжих, амьдрах орчны шууд хомсдол хуваагдалд орох	Ховор болон нэн ховор амьтад, тэдгээрийн нүүдэл, шилжилт хөдөлгөөний ажиглалт, судалгаанд үндэслэн замуудын зэрлэг амьтад ихээр гардаг, эрсдэл өндөртэй хэсгүүдийг үнэлж, шаардлагатай тохиолдолд хурдны хязгаарыг бууруулж, анхааруулах тэмдэг тэмдэглэгээг байрлуулах	Төслийн талбайн ойр орчимд болон замын дагуу	Дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийн зардал	6-11 сар	
20.	Амьтад тээврийн хэрэгсэлд дайруулах, хууль бус агнуур	Хууль бусаар амьтан агнах, ургамал түүх, тэдгээрийн гаралтай түүхий эдийг ашиглахыг хориглох тухай ажилчдад мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах	Уурхайн ажилчид		6-11 сар	
21.	Уурхайн ухмал, карьерт амьтан унаж үхэх, гэмтэх	Нөхөн сэргээлтийг богино хугацаанд хийх, боломжгүй тохиолдолд хайс, хашлага хийх	Төслийн талбайд		6-11 сар	
НИЙТ (мян.төг)					1 500.0	

4.1.2. Ногоон байгууламж, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Монгол улсын ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлигаар Эх дэлхий, байгаль орчноо хайрлан зохицон амьдрах Монгол уламжлал, зан заншлаа эрхэмлэн, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг санаачлан өрнүүлж байгаа билээ. Энэхүү хөдөлгөөний хүрээнд “Идэр макс” ХХК нь ашиглалтын талбай доторх боломжтой газруудад мод тарих, ногоон байгууламж байгуулахаар төлөвлөн энэхүү бүлэгт орууллаа.

Хүснэгт 23. Ногоон байгууламж нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний нийт зардал

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.
1.	Ногоон байгууламж	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд холбогдох төрийн байгууллагуудтай хамтран, газар заалган мод тарих	га	1	1 000.0	1 000.0	6-11 сар	MNS 5917:2008 MNS 5915 : 2008
2.	Нөхөн сэргээлтийн зардал	Техникийн болон биологийн нөхөн сэргээлт, мониторинг	га	4.6	71 000.0	71 000.0	6-11 сар	
2026 оны нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний нийт зардал /мян.төг/						72 000.0		

4.1.3. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

“Идэр Макс” ХХК-ны Дундговь аймгийн Өлзийт, Сайнцагаан сумын нутаг дэвсгэрт хэрэгжих Уушиг-Уул 1 нэртэй хайлуур жоншны орд ашиглах төслийн талбайн үйлдвэрлэлийн болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд орших иргэд, айл өрхүүд байхгүй учир нүүлгэн суурьшуулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах шаардлагагүй гэж үзлээ.

4.1.4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

Уул уурхайн үйл ажиллагааны дараа нөхөн сэргээлтийг маш сайн хийсэн ч нөлөөлөл ямар нэг хэлбэрээр үлддэг. Тэрхүү нөлөөллийг бууруулах олон арга байдгийн нэг нь дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагаа юм. Тиймээс төсөл хэрэгжүүлэгч “Идэр макс” ХХК нь уурхайн БОМТ-ний хүрээнд биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний стратеги төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай бөгөөд түүний хэрэгжилтийн тайланг жил бүрийн БОМТ-ний хэрэгжилтийн тайланд тусгаж байх үүрэгтэй. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ гэдэг нь байгалийн газарзүйн тогтцын хувьд төсөөтэй газар нутгийг сонгон авч биологийн олон янз байдлыг хамгаалах, сайжруулахад чиглэсэн хамгааллын менежментийн багц арга хэмжээ юм. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

хэрэгжүүлсний үр дүнд тухайн газрын биологийн олон янз байдал хэвийн нөхцөлөөс илүүтэйгээр сайжирсан байх нь дүйцүүлэн хамгааллын эцсийн үр дүн болно. “ИДЭР МАКС” ХХК -ийн Дундговь аймгийн Өлзийт, Сайнцагаан сумдын нутаг дэвсгэрт хэрэгжих “Уушиг-Уул 1” хайлуур жоншны ордын ил, далд аргаар ашиглах төслийн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардалд 2026 оны хувьд 16 000.0 төгрөг зарцуулах тооцоолол гаргасан. Тус арга хэмжээг **БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ** тухай хуулийн 3.1.11-т "биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах" гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг гэж тусгасан байдаг тул төсөл хэрэгжүүлэгч нь уул уурхайн олборлолт 2026 онд хийсэн тохиолдолд тус зардлыг хэрэгжүүлэх шаардлагатай юм.

4.1.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн ашиглалтын талбай орчимд хийгдсэн судалгаагаар ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор бүртгэгдээгүй. Гэвч уурхайн газар шорооны ажлын явцад соёлын өв олдхоыг үгүйсгэж болохгүй. Тиймээс уурхай үйл ажиллагааны явцад соёлын өв олдсон тохиолдолд соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санд заавал бүртгүүлнэ. Хэрэв уурхай ашиглалтын явцад соёлын өв илэрсэн олдсон тохиолдолд уурхайн үйл ажиллагааг түр зогсоон холбогдох мэргэжлийн байгууллагаар авран хамгаалах малтлага судалгааг хийлгэх нь зүйтэй.

4.1.6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 24. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний нийт зардал

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг, мян.төг	Тоо хэм жээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.	9.
1.	Ахуйн	Ангилан ялгалттай хогийн савыг хотхоны талбайд байрлуулах	Төслийн талбай	ш	250.0	2	500.0	6-11 сар	Хог хаягдлын тухай хууль; MNS 5344 : 2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага; Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт. Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам, Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 9/8 дугаар тогтоолоор баталсан “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах,
2.		Хог хаягдлыг дахин боловсруулах, ашиглах үндэсний компаниудтай хамтран ажиллаж, хог хаягдлын хэмжээг бууруулах	Төслийн хүрээнд	Үйл ажиллагааны зардалд тусгах					
3.		Хог хаягдал түр хадгалах цэг орчимд тогтмол ариутгал, цэвэрлэгээ хийх	Хог хаягдал хадгалах түр цэг	Удаа	60.0	10	600.0	6-11 сар	
4.		Хог хаягдлыг ангилан ялгаж, гэрээт ААН-ээр төслийн талбайгаас тогтмол зөөвөрлүүлэх	Төслийн талбай	тн	Нэг удаа тээвэрлэхэд 40.0	12	300.0	6-11 сар	
5.		Ажилчдад болон тээврийн жолооч нарт хог хаягдлаа бууруулах, ангилан ялгах талаар дадал зуршил эзэмшүүлэх сургалт орох, мэдээллийн самбарт мэдээлэл байршуулах	Төслийн ажилчдад	ш	300.0	1	300.0	6-11 сар	
6.		Төслийн талбай орчмын эргэн тойронд 50 м зайд цэвэрлэгээ хийх	Төслийн талбай орчмын 50 м	Удаа	250.0	2	500.0	6-11 сар	
7.		Аюултай	Засвар, хяналтын ажлын үеэр хэрэглэсэн тос тосолгооны сав,	Төслийн талбай	Удаа	Гэрээнд заасан дүнгээр	2	Үйл ажиллагааны	

		цэвэрлэгээний бодис, эд анги дугуй зэргийг хог хаягдлыг ангилан ялгах журмын дагуу түр хадгалан, тусгай зөвшөөрөл бүхий байгууллагад өгөх					зардалд тусгах		цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”
8.		Аюултай хог хаягдлыг ангилан ялгах зориулалтын сав байршуулах /Агуулах, засварын хэсэг /	Тухайн байршилд	ш	500.0	1	500.0	6-11 сар	
9.		Аюултай хог хаягдлын батлагдсан маягт журмын дагуу хог хаягдлын тоо бүртгэл тухай бүрд хөтөлж, тогтоосон хугацаанд тайлагнах	Төслийн хүрээнд	Үйл ажиллагааны зардалд тусгах				6-11 сар	
2026 оны хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний нийт зардал /мян.төг/									2 700.0

4.1.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

ИДЭР МАКС” ХХК -ийн Дундговь аймгийн Өлзийт, Сайнцагаан сумдын нутаг дэвсгэрт хэрэгжих “Уушиг-Уул 1” хайлуур жоншны ордын ил, далд аргаар ашиглах төслийн үйл ажиллагааны явцад гэнэтийн осол эрсдэл гарахаас сэргийлж ажиллах шаардлагатай. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд урьдчилсан байдлаар 2026 онд 11 200.0 төгрөг зарцуулах шаардлагатай гэж тооцооллоо.

Хүснэгт 25. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний нийт зардал

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Нэгжийн өртөг, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	1.	2.	3.	4.	5.	6.	7.	8.
1.	Байгалийн гамшигт үзэгдлүүд	Эрх бүхий байгууллагаар Гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийлгэх.	Төслийн үйл ажиллагааны үед	Үйл ажиллагааны зардалд тусгах			6-11 сар	Засгийн газрын 2018 оны 67 дугаар тогтоолын хавсралт Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/

2.		Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг дараах тохиолдолд тодотгох. Үүнд: – Төлөвлөгөөний бүтэц агуулгад өөрчлөлт орсон тохиолдолд – Гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх явцад илэрсэн дутагдал, сул талыг арилгах зорилгоор – Аюулт үзэгдэл, осол болон бусад шаардлагатай үед	Төслийн үйл ажиллагааны үед	Үйл ажиллагааны зардалд тусгах			Шаардлага гарсан үед	Монгол улсын шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалын 3 дугаар хавсралт Байгууллага аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар
3.		ОБЕГ-ын мэдээ болон цаг агаарын станцын мэдээг тогтмол хянаж үйл ажиллагаанд харгалзан үзэж, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээ, дохиог хүмүүст дамжуулан анхааруулга өгч байх	Ажилчид болон орон нутгийн иргэд	Үйл ажиллагааны зардалд тусгах			6-11 сар	Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/
4.	Газар хөдлөл	Орон нутгаас зохион байгуулах газар хөдлөлийн аюулын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөөний талаарх мэдлэг өгөх сургалт хөтөлбөр болон турших дасгал сургуулилалтад ажилчдыг хамруулах,	Ажилчид	2 000.0	1	2 000.0	6-11 сар	MNS 4968:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага. MNS 4969:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуйн сургалтын зохион байгуулалт үндсэн дүрэм MNS 5390:2004 Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага. MNS ISO 13688:2000 Хөдөлмөрийн

5.	Аянга цахилгаан	Хамгаалах газардуулгын байгууламж буюу тэглэлтийн стандартаар тогтоосон шаардлагыг ашиглалтын үед тогтмол шалгаж нийцүүлж байх	Эрчим хүчний байгууламж, Шатахуун түгээх станц	1 000.0	1	1 000.0	6-11 сар	<p>аюулгүй ажиллагаа эрүүл ахуй. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага.</p> <p>MNS 4970:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Өргөх, зөөх ачааны массын дээд хэмжээ.</p> <p>MNS 4992:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй.</p>
6.		Цаг агаарын улирлын, сарын, 7 хоногийн, өдөр тутмын урьдчилсан мэдээнүүдийг төслийн үйл ажиллагаанд тогтмол ашиглах	Төслийн талбай	Үйл ажиллагааны зардалд тусгах			6-11 сар	
7.	Үер	Төслийн эзэмшил талбайг хаврын шар ус, хур бороо элбэгтэй үед үерт автахас сэргийлж ус зайлуулах суваг хоолой, даланг технологийн дагуу мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Төслийн талбай	Үйл ажиллагааны зардалд тусгах			6-11 сар	
8.	Гал түймэр	Галын аюулын талаар анхааруулга самбарыг эзэмшлийн объект бүрд онцлогийг нь тусган тавих. Гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бэлэн байлгах.	Төслийн талбай	3 000.0	1	3 000.0	6-11 сар	
9.	Халдварт өвчин	Хоолны газрын эрүүл ахуйг сахиулах, ажилчдыг хувийн эрүүл ахуйн дадал зуршлыг хэвшүүлэх сургалт зохион байгуулах	Төслийн ажилчид	Үйл ажиллагааны зардалд тусгах			6-11 сар	

10.	Үйл ажиллагааны осол гэмтэл	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	Төслийн ажилчид	Үйл ажиллагааны зардалд тусгах			6-11 сар
11.		Бүх ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх,	Төслийн ажилчид	3 000.0	1	3 000.0	6-11 сар
12.		Анхны тусламжийн эмийн сан байршуулах	Ажилчдын байр	1 200.0	1	1 200.0	6-11 сар
13.	Автомашины осол	Замын хөдөлгөөний аюулгүйн дүрмийг мөрдөөгүй тохиолдолд жолоочид авах арга хэмжээний тухай бодлого боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах	Тээврийн хүнд машин механизм болон тээврийн хэрэгслүүд	1 000.0	1	1 000.0	6-11 сар
2026 оны осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний нийт зардал /мян.төг/							11 200.0

4.1.8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хайлуур жоншны орд ашиглах төслийн явцад байгаль хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахтай холбоотой арга хэмжээг тухай бүрд авч хэрэгжүүлэх шаардлагатай. Төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө холбогдох мэргэжлийн байгууллагаар Газрын чанарын улсын хянан баталгааг хийлгэх шаардлагатай.

Төслийн хэрэгжилтийн үед авч хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын асуудал ихээхэн чухал үүрэгтэй юм. Удирдлага зохион байгуулалтын менежментийг дараах чиглэлд хандуулан төлөвлөгөөндөө тусгах нь зүйтэй.

- Байгаль орчны асуудал хариуцаж ажиллах ажилтан албан хаагч, түүний үүрэг хариуцлага
- Байгаль орчны чиглэлээр орон нутгийн иргэд, олон нийттэй хамтран ажиллах ажлын чиглэл
- Ажилтан албан хаагчдын дунд зохион байгуулах сургалт, танилцуулгын ажил, мэдээллийн самбар
- Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны чиглэлээр хийгдэх ажил
- Байгаль орчин хамгааллын чиглэлээр хийгдэх хяналт, шалгалтын хуваарь, бүртгэл хөтлөх, түүнийг хариуцах үүрэг хариуцлагын систем
- Байгаль орчин хамгааллын чиглэлээр бусад байгууллагатай хамтран ажиллах ажлын төлөвлөгөө, хуваарь
- Байгаль орчин хамгааллын чиглэлээр хийгдэх ажлын төсөв санхүүгийн зохицуулалт
- Эдгээр ажлуудыг хариуцан гүйцэтгэх байгаль орчны мэргэжилтэн ажиллуулах

Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр: Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулж батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллах, жилийн эцэст БОМТ-ний хэрэгжилтийг Дундговь аймгийн БОАЖГ-аар дүгнүүлэх, оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах, Онцгой байдлын газар /ОБГ/, Мэргэжлийн хяналтын газар /МХГ/ зэрэг байгууллагуудаар төслийн үйл ажиллагаанд хяналт тавиулж, хамтран ажилчдынхаа дунд галын аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын сургалтуудыг зохион байгуулах, осол эрсдэлээс хамгаалах ажлыг зохион байгуулах шаардлагатай.

Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах ажлууд: Төслийн ажилчид, албан хаагчдыг үр бүтээлтэй, осол авааргүй ажиллуулах тулд Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны арга хэмжээг цаг тухай төлөвлөн, ажиллагсдад улирал бүр зааварчилгаа өгүүлэх, үе шаттайгаар хянан шалгах арга хэмжээнүүдийг өөртөө багтаасан Компанийн Хөдөлмөр Хамгаалал, Аюулгүй Ажиллагааны (ХХАА) системийг бий болгож түүн дээр үндэслэн, олон улсын болон Монгол улсын холбогдох хууль тогтоомжуудын шаардлагуудад нийцсэн журам стандартуудыг харьяалагдах байгууллагуудтай хамтран боловсруулж, батлуулан (Монгол улсын засгийн газраас 2005 онд баталсан ХХАА, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний хөтөлбөрийн 2.1.4, 2.1.6 заалтад тулгуурлан) мөрдөж ажиллах нь төсөл хэрэгжүүлэгчийн үүрэг юм.

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр ажилчдад ажлын байрны онцлог тус бүрд нийцсэн ажлын хувцас хэрэгслийг олгох, хортой нөхцөлд ажилладаг ажилтанд хор саармагжуулах бүтээгдэхүүнийг ажлын байранд тогтмол олгох, жил бүр эрүүл

мэндийн төвтэй хамтран нийт ажиллагсдаа эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулан, нарийн мэргэжлийн эмч нараар ажил, мэргэжлийн онцлогоос шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх сургалт, зөвлөгөө өгүүлэх, шаардлагатай тохиолдолд ажилтнуудыг амбулаториор эмчилгээнд хамруулах, машин тоног төхөөрөмж дээр ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгааг байрлуулж, ажилд гарахын өмнө ажиллагсдад аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгөх, ажлын байранд яаралтай үед хэрэглэх түргэн тусламжийн багаж хэрэгсэл, эм тариа бэлтгэх ажлуудыг төлөвлөлөө.

Хүснэгт 26. Удирдлага, зохион байгуулалтын талаар авах арга хэмжээний зардал

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хуваарь
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх		Уурхайн дотоод төлөвлөлтөөр	6-11 сар
2	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 2 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах		Осол эрсдэлийн МТ-нд тусгагдсан	6-11 сар
3	Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах		Осол эрсдэлийн МТ-нд тусгагдсан	6-11 сар
4	Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах. Ажилчдыг ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах, Хордлого тайлах хүнс, эмээр хангаж байх		Уурхайн дотоод төлөвлөлтөөр	6-11 сар
5	Галын аюулаас хамгаалах хэрэгсэл, эрүүл ахуйн хэрэгслээр хангах		Осол эрсдэлийн МТ-нд тусгагдсан	6-11 сар
6	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлуудын жил бүрийн тайланг БОАЖЯ болон Дундговь аймгийн ЗДТГ-т хүргүүлэх		Уурхайн дотоод төлөвлөлтөөр	6-11 сар
7	Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, сургалт аян, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах		Осол эрсдэлийн МТ-нд тусгагдсан	6-11 сар
9	Тусгай зөвшөөрөлтэй талбайд газрын төлөв байдлын чанарын улсын хянан баталгааг тогтоосон хугацаанд эрх бүхий байгууллагаар хийлгэж байх		Уурхайн дотоод төлөвлөлтөөр	6-11 сар
2026 оны удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний нийт зардал /мян.төг/			-	

4.1.9. Байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар Уушиг-Уул 1 нэртэй хайлуур жоншны орд ашиглах төслийг хэрэгжүүлэхдээ тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг төсөл хэрэгжүүлэгч “Идэр макс” ХХК-д өгөгдсөн.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсан байна. Хуулийн дээрх заалтыг удирдлага болгон төсөл хэрэгжүүлэх явцад “Идэр макс” ХХК-аас байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон Байгаль орчин ногоон хөгжлийн яамны сайдын 2014 оны 04-дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, “Байгаль орчны стратегийн болон хуримтлах нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ийн 4-р хэсэг болох Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлалд заасны дагуу байгалийн бүрдэл тус бүрээр энэхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг (ОХШХ) боловсруулав.

Хүснэгт 27. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн нийт зардал

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Агаарын чанар					
1.	Агаарт хаягдах түгээмэл бохирдуулагчид(NO ₂ , SO ₂ , CO)-ын агууламжид хяналт тавих, мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэх	Уурхайн орчим дахь агаар бохирдуулагчийн тархалтыг гаргахад төлөөлөх чадвартай нийт 4 цэгт (уурхайн олборлолтын талбай, овоолго, дотоод тээврийн зам, уурхайн тосгон)	Жилд 2 удаа	250.0	<ul style="list-style-type: none"> ❖ MNS 4585: 2016 Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага ❖ MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага ❖ MNS 0017-5-1-21:1992 Дуу чимээ- хэвийн норм, түвшний хэмжээ
2.	Агаарын тоос, тоосонцрын (TSP, PM ₁₀ , PM _{2.5}) шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх				
3.	Дуу шуугиан, чичиргээ				
Усны хяналт шинжилгээ					
4.	Усны хүнд металлын шинжилгээ	Уурхай ашиглалтын худаг-1,	Жилд 1 удаа	90.0	<ul style="list-style-type: none"> ❖ MNS 0900: 2018, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
Хөрсний бохирдол					
5.	Хөрсний үржил шимийн үзүүлэлт (рН, ялзмаг, карбонат, Ca ²⁺ Mg ²⁺ , K ₂ O, P ₂ O ₅) механик бүрэлдэхүүн, хүнд металлууд Cr, Pb, Cd, Ni Zn	Шимт хөрсний овоолго - 1, хөрсний овоолго-1, ажилчдын тосгон-1, засварын газрын гадна-1 нийт 4 цэгт хөрсний хяналт мониторингийг хийнэ.	Жилд 1 удаа	560.0	<ul style="list-style-type: none"> ❖ MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ ❖ MNS 3310:1991, Хөрсний агрохимийн үзүүлэлтүүдийг тодорхойлох ❖ MNS 3298:1991 хөрсний шинжилгээний дээж авах ерөнхий шаардлага ❖ MNS 3307:1991, хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга
2026 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын нийт зардал /мян.төг/					900.0

4.1.10. БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Төсөл хэрэгжүүлэгч “Идэр макс” ХХК жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайланг хүргүүлэх ба төсөл хэрэгжих аймгийн байгаль орчны газарт тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11 сарын 01 дотор хүргүүлнэ. Хүснэгт 28

Хүснэгт 28. БОМТ-г оролцогч талуудад тайлагнах хуваарь

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1.	Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам	БОМТ-ний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр илэрхийлсэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна	Жил бүрийн 12 дугаар сарын 30-аас өмнө	Үйл ажиллагааны зардалд тусгах	Удирдлага болон Байгаль орчны мэргэжилтэн Байгаль орчны мэргэжилтэн болон ХАБЭА	Улаанбаатар хот
2.	Дундговь аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар	Тайлангийн эх хувь болон цахим хэлбэрээр албан бичгийн хамт		Жил бүрийн 11 дүгээр сарын 01-ээс өмнө			Дундговь аймаг

АРВАН ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино. Ингэхдээ тухайн арга хэмжээ бүрийг төсөл хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлж чадахуйц, бодитойгоор төлөвлөх нь чухал.

Төслийн 5 жилийн БОМТ-г БОАЖСайдын 2019 оны А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хэвн батлах, тайлагнах журам”-ыг баримтлан боловсруулсан бөгөөд төслийн үйл ажиллагааны онцлог, байршил зэргээс шалтгаалан БОМТ-нд нүүлгэн шинжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно.

Энэхүү БОМТ-нд төслийн ТЭЗҮ-тэй уялдуулан, төсөл хэрэгжүүлэгчтэй зөвшилцсөний үндсэн дээр сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө(21), осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө(13), хог хаягдлын менежментийн төлөвлөгөө(8), биологийн олон энз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө(7), нөхөн сэргээлтний төлөвлөгөө(8), тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө(20), байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө(3) болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөр(5)-ийн нийт 82 ажил багтсан бөгөөд төслийн 2022 оны менежментийн төлөвлөгөөний ажилд нийт 16.3 сая төгрөг, 2022-2026 он хүртэлх 5 жилийн хугацаанд нийт 322.3 сая.төг зарцуулахаар төлөвлөв.

Хүснэгт 12.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

Агуулга	Ашиглалтын жилүүдийн зардал, сая.төг					Нийт зардал
	2022	2023	2024	2025	2026	
Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1.7	9.5	1.5	1.5	1.5	16.7
Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	3.5	43.1	20.6	13.3	11.2	91.7
Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	7.1	2.7	2.7	2.7	2.7	17.9
Биологийн олон энз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	4.0	18.0	23.0	16.0	16.0	77.0
Нөхөн сэргээлтний төлөвлөгөө	-	-	-	48.0	72.0	120.0
Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-	-	-	-	-	-
Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-	-	-	-	-	-
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	-	0.9	0.9	0.9	0.9	3.6
Нийт	16.3	74.2	48.7	81.5	103.4	322.3

